



МОНГОЛ УЛСЫН
ХӨРӨНГИЙН
ЗАХ ЗЭЭЛИЙН

**СТАТИСТИК
ҮЗҮҮЛЭЛТҮҮД**

2017 он



7010-0261, 7010-0263



info@tdbcapital.mn



www.tdbcapital.mn

МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/ мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК нь мэдээллийн эх үүсвэрийн үнэн бодит байдал баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК хариуцлага хүлээхгүй болно.

Энэхүү бүтээлийн бүх эрх хуулиар хамгаалагдсан болно. Бүтээлийг зөвшөөрөлгүйгээр бүтнээр болон хэсэгчлэн нийтлэх, дахин хэвлэх, хайлтын системд байршуулах, цахим хэлбэрт оруулах, механик, фото хуулбар зэрэг бусад аль ч хэлбэрээр хувиран олшруулах, түгээн тараахыг хатуу хориглоно.

Зохиогчийн эрхээр хамгаалагдсан © 2018 он. “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК

АГУУЛГА

НЭГ. МОНГОЛ УЛСЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ХӨГЖИЛ

1.1	Санхүүгийн зах зээлийн хөгжил	9
1.2	Хөрөнгийн зах зээлийн түүхэн дэх онцлох үйл явдал	10
1.3	Хөрөнгийн зах зээлийн хөгжлийн үзүүлэлт	12

ХОЁР. ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛД ОРОЛЦОГЧИД

2.1	Зохицуулагч байгууллага	16
2.2	Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага	17
2.3	Үнэт цаасны өмчлөх эрх бүртгэлийн байгууллага	17
2.4	Үнэт цаасны төлбөр тооцоо гүйцэтгэх байгууллага	18
2.5	Үнэт цаасны компани	19

ГУРАВ. ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧИД

3.1	Үнэт цаасны данс	24
3.2	Арилжааны идэвх	25
3.3	Хувьцааны төвлөрөл	26

ДӨРӨВ. ХУВЬЦААТ КОМПАНИ

4.1	Бүртгэлтэй хувьцаат компанийн тоо	28
4.2	Зах зээлийн үнэлгээ	29
4.3	Арилжааны идэвх	30
4.4	Санхүүгийн үзүүлэлт	32
4.5	Компанийн засаглал	34
4.6	Ногдол ашиг	35

ТАВ. БҮРТГЭЛТЭЙ ҮНЭТ ЦААС

5.1	Биржийн зах зээлд бүртгэлтэй үнэт цаас	37
5.2	Биржийн бус зах зээлд бүртгэлтэй үнэт цаас	38
5.3	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас	39

ЗУРГАА. ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖАА

6.1	Арилжааны ерөнхий үзүүлэлтүүд	42
6.2	Хувьцааны арилжаа	43
6.3	Засгийн газрын үнэт цаасны арилжаа	46
6.4	Компанийн бондын арилжаа	48

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

IPO	Initial Public Offering буюу олон нийтэд хувьцаагаа анх удаа санал болгох
FPO	Follow On Public Offer буюу нэмэлт хувьцаа гаргах
ААН	Аж ахуйн нэгж
ББСБ	Банк бус санхүүгийн байгууллага
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ДЦС	Дулааны цахилгаан станц
ЗГҮЦ	Засгийн газрын үнэт цаас
ЗЗҮ	Зах зээлийн үнэлгээ
МИК	Монголын ипотекийн корпораци
МҮЦБ	Монголын үнэт цаасны бирж
МХБ	Монголын хөрөнгийн бирж
НҮБ	Нэгдсэн үндэсний байгууллага
ОССК	Орон сууцны санхүүжилтийн корпораци
СЗХ	Санхүүгийн зохицуулах хороо
ТЗК	Тусгай зориулалтын компани
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ҮЦК	Үнэт цаасны компани
ҮЦТТТХТ	Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв
ҮЦТХТ	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв
ХЗХ	Хадгаламж, зээлийн хоршоо
ХК	Хувьцаат компани
ХОЗ	Хөрөнгө оруулалтын зөвлөх
ХХБ	Худалдаа Хөгжлийн банк
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХЭХ	Хувьцаа эзэмшигчдийн хурал

ХҮСНЭГТИЙН ТАЙЛБАР

Хүснэгт 1.	ТОП-20 индексийн сагсыг бүрдүүлж буй ХК, 2017 он	13
Хүснэгт 2.	Монголын хөрөнгийн бирж, 2017 он	17
Хүснэгт 3.	Монголын үнэт цаасны бирж, 2017 он	17
Хүснэгт 4.	МХБ-ийн гишүүн үнэт цаасны компаниудын клиринг банк сонгосон байдал, 2017 он	18
Хүснэгт 5.	Үнэт цаасны компаниуд, тусгай зөвшөөрлийн төрлөөр	20
Хүснэгт 6.	Хамгийн их хөрөнгөтэй ҮЦК-иудын санхүүгийн зарим үзүүлэлт, тэрбум төгрөг	21
Хүснэгт 7.	Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгийн шаардлага, сая төгрөг	21
Хүснэгт 8.	Биржид бүртгэлтэй 219 хувьцаат компанийн хувьцааны төвлөрөл, 2017 он	26
Хүснэгт 9.	Хувьцаат компанийн хувьцаа арилжагдсан өдрүүд, 2017 он	30
Хүснэгт 10.	2017 онд 125-аас олон өдөр арилжигдсан хувьцаа	30
Хүснэгт 11.	Ногдол ашиг хуваарилсан хувьцаат компаниуд, 2017 он	35
Хүснэгт 12.	Биржийн бус зах зээлд бүртгэлтэй хувьцаа, 2017 он	38
Хүснэгт 13.	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас	39
Хүснэгт 14.	Хувьцааны анхдагч зах зээлийн арилжааны түүх, 2010-2017 он	43
Хүснэгт 15.	Анхдагч зах зээлийн арилжаанд оролцсон хөрөнгө оруулагчид, 2017 он	44
Хүснэгт 16.	IPO, 2017 он	44
Хүснэгт 17.	МХБ дээр явагдсан багцын арилжаа, 2017 он	45
Хүснэгт 18.	Монголын хөрөнгийн бирж дээр гаргасан компанийн бондын түүх, 2001-2017 он	48

ЗУРГИЙН ТАЙЛБАР

Зураг 1.	Санхүүгийн салбарын хөрөнгийн бүтэц, 2017 он	9
Зураг 2.	Санхүүгийн салбарын хөрөнгө 2010-2017 он, тэрбум төгрөг	9
Зураг 3.	Санхүүгийн салбарын цэвэр ашгийн бүтэц, 2017 он	9
Зураг 4.	Санхүүгийн салбарын нийт цэвэр ашиг, алдагдал, 2010-2017 он, тэрбум төгрөг	9
Зураг 5.	ДНБ-д эзлэх зэх зээлийн үнэлгээ, 2017 он	12
Зураг 6.	Хөрвөх чадвар, 2017 он	12
Зураг 7.	Хөрөнгийн зах зээлийн зарим үзүүлэлт	12
Зураг 8.	Монголын хөрөнгийн биржийн ТОП-20 индекс	13
Зураг 9.	Монгол улсын санхүүгийн зах зээлийн зохицуулалт	16
Зураг 10.	Үнэт цаасны компаниудын тоо, тусгай зөвшөөрлийн төрлөөр	19
Зураг 11.	Үнэт цаасны компани болон тэдгээрийн салбарууд	19
Зураг 12.	ҮЦК-иудын санхүүгийн үзүүлэлтүүд, тэрбум төгрөг	21
Зураг 13.	2017 оны хувьцааны нийт арилжаа	22
Зураг 14.	2017 оны ЗГҮЦ-ны нийт арилжаа	22
Зураг 15.	2017 оны компанийн бондын нийт арилжаа	22
Зураг 16.	Нийт үнэт цаасны дансны тоо, мянган данс	24
Зураг 17.	Шинээр нээгдсэн дансны тоо, мянган данс	24
Зураг 18.	Шинээр нээгдсэн дансны тоо, хөрөнгө оруулагчдын төрлөөр, 2010-2017 он	24
Зураг 19.	Хөрөнгө оруулагчдын арилжаанд эзлэх хувь, 2010-2017 он	25
Зураг 20.	Хөрөнгө оруулагчдын арилжаанд эзлэх хувь, 2017 он	25
Зураг 21.	Хөрөнгө оруулагчдын арилжааны идэвх, 2010-2017 он, тэрбум төгрөг	25
Зураг 22.	Хувьцаат компанийн хувьцааны эзэмшигчдийн бүтэц, 2017 он	26
Зураг 23.	Хувьцаат компанийн төвлөрөл, 2017 он	26
Зураг 24.	Биржид бүртгэлтэй ХК-ийн тоо, өмчийн хэлбэрээр, 2010-2017 он	28
Зураг 25.	Биржийн бүртгэлээс хасагдсан болон шинээр бүртгэгдсэн ХК-ийн тоо, 2010-2017 он	28
Зураг 26.	Биржид бүртгэлтэй ХК-ийн тоо, салбараар, 2017 он	28
Зураг 27.	Хувьцаат компанийн тоо, биржийн ангиллаар, 2017 он	28
Зураг 28.	Хувьцаат компанийн зах зээлийн үнэлгээ, биржийн ангиллаар, тэрбум төгрөг	29
Зураг 29.	Хувьцаат компанийн зах зээлийн үнэлгээ, салбараар, 2017 он	29
Зураг 30.	Хамгийн өндөр зах зээлийн үнэлгээтэй ХК, 2017 он	29
Зураг 31.	Хувьцаат компанийн хувьцааны энгийн арилжаа, тэрбум төгрөг	31
Зураг 32.	Нэгж хувьцааны ханшийн өсөлт болон эзэмших хугацааны өгөөж хамгийн өндөр хувьцаа, 2017 он	31
Зураг 33.	Хамгийн их бууралттай хувьцаа, 2017 он	31
Зураг 34.	Хувьцаат компаниудын нийт хөрөнгийн бүтэц, 2017 он	32
Зураг 35.	Хувьцаат компаниудын хөрөнгө, 2010-2017 он, тэрбум төгрөг	32
Зураг 36.	2017 онд хамгийн их хөрөнгөтэй хувьцаат компаниуд, тэрбум төгрөг	32
Зураг 37.	Хувьцаат компаниудын ашигт ажиллагаа, 2010-2017 он, тэрбум төгрөг	33
Зураг 38.	2017 онд хамгийн их ашигтай ажилласан хувьцаат компани, тэрбум төгрөг	33
Зураг 39.	2017 онд хамгийн их алдагдалтай ажилласан хувьцаат компани, тэрбум төгрөг	33
Зураг 40.	Хувьцаат компанийн үндсэн үүргийн хэрэгжилт, 2017 он	34
Зураг 41.	МХБ болон МҮЦБ-д бүртгэлтэй ХК-ийн тоо, 2010-2017 он	34
Зураг 42.	Ногдол ашиг хуваарилсан ХК-ийн тоо, 2010-2017 он	34
Зураг 43.	Хувьцаа эзэмшигчдийн хурлаа хуралдуулсан ХК-ийн тоо, 2010-2017 он	34
Зураг 44.	Санхүүгийн тайлангаа хуульд заасан хугацаанд ирүүлсэн ХК-ийн тоо, 2010-2017 он	34
Зураг 45.	Ногдол ашиг хуваарилалт, тэрбум төгрөг	35
Зураг 46.	Биржийн зах зээлд бүртгэлтэй үнэт цаасны тоо, тэрбум ширхэг	37
Зураг 47.	Биржийн зах зээлд бүртгэлтэй хувьцааны тоо, тэрбум ширхэг	37

ЗУРГИЙН ТАЙЛБАР

Зураг 48.	Биржийн зах зээлд бүртгэлтэй бондын тоо, сая ширхэг	37
Зураг 49.	“Эрдэнэс таван толгой” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц, 2017 он	38
Зураг 50.	Биржийн бус зах зээлд бүртгэлтэй бондын тоо, мянган ширхэг	38
Зураг 51.	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны үнийн дүн болон зээлдэгчдийн тоо, тэрбум төгрөг	39
Зураг 52.	Үнэт цаасны арилжаа, тэрбум төгрөг	42
Зураг 53.	2017 оны анхдагч зах зээлийн арилжаа, тэрбум төгрөг	42
Зураг 54.	2017 оны хоёрдогч зах зээлийн арилжаа, тэрбум төгрөг	42
Зураг 55.	Хувьцааны арилжаа, тэрбум төгрөг	43
Зураг 56.	Хувьцааны хоёрдогч зах зээлийн энгийн арилжаа, биржийн ангиллаар, 2017 он	45
Зураг 57.	Хувьцааны хоёрдогч зах зээлийн энгийн арилжаа, үйл ажиллагааны салбараар, 2017 он	45
Зураг 58.	ЗГҮЦ-ны арилжаа, 2014-2017 он, тэрбум төгрөг	46
Зураг 59.	ЗГҮЦ-ны арилжаа, 2017 он, тэрбум төгрөг	46
Зураг 60.	2017 оны ЗГҮЦ-ны анхдагч зах зээлийн арилжаа, хугацааны ангиллаар	46
Зураг 61.	2017 оны ЗГҮЦ-ны захиалга болон нийлүүлэлт, сараар, тэрбум төгрөг	46
Зураг 62.	2017 онд арилжаалагдсан ЗГҮЦ-ны хүү, үнэт цаасны хугацааны ангиллаар, сараар	47
Зураг 63.	2017 оны компанийн бондын арилжаа	48



МОНГОЛ УЛСЫН
ХӨРӨНГИЙН
ЗАХ ЗЭЭЛИЙН

ХӨГЖИЛ

1

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ХӨГЖИЛ 2017

САНХҮҮГИЙН САЛБАРЫН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ

Банк

Нийт банкны тоо.....	14
Салбар нэгжийн тоо.....	1,625
Ажиллагсдын тоо.....	17,031
Харилцагчдын тоо.....	6,841,409

Банк бус санхүүгийн байгууллага

Нийт ББСБ-ын тоо.....	534
Салбар нэгжийн тоо.....	164
Ажиллагсдын тоо.....	2,473
Харилцагчдын тоо.....	1,387,896

Үнэт цаас

Нийт ҮЦК-ийн тоо.....	52
Салбар нэгжийн тоо.....	16
Ажиллагсдын тоо.....	329
Харилцагчдын тоо.....	906,053

Даатгал

Нийт даатгалын компанийн тоо.....	17
Салбар нэгжийн тоо.....	495
Ажиллагсдын тоо.....	1,355
Даатгуулагчдын тоо.....	1,015,265

Хадгаламж зээлийн хоршоо

Нийт ХЗХ-ны тоо.....	290
Салбар нэгжийн тоо.....	22
Ажиллагсдын тоо.....	501
Гишүүдийн тоо.....	55,624

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ

ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

2,440.2

тэрбум төгрөг

ЗЗҮ/ДНБ ХАРЬЦАА

9.0%

ХӨРВӨХ ЧАДВАР

3.2%

ТОП-20 ИНДЕКСИЙН ХААЛТ

20,106.8

нэгж

ТОП-20 ИНДЕКСИЙН ДУНДАЖ
ӨСӨЛТ

18.2%

MSE ALL ИНДЕКСИЙН ХААЛТ

1,106.7

нэгж

MSE ALL ИНДЕКСИЙН ДУНДАЖ
ӨСӨЛТ

5.3%


1.1 САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ХӨГЖИЛ

Санхүүгийн салбарын хөрөнгө

Монгол улсын санхүүгийн зах зээлд оролцогчдын нийт хөрөнгө 2017 оны байдлаар 26.5 их наяд төгрөг байгаагаас банкуудын хөрөнгө 94.5%, үнэт цаасны компаниудын хөрөнгө 0.4%, даатгалын компаниудын хөрөнгө 0.9%, банк бус санхүүгийн байгууллагуудын хөрөнгө 3.7%, хадгаламж зээлийн хоршоодын хөрөнгө 0.6% тус тус эзэлж байна.


2010-2017 онд санхүүгийн салбарын нийт хөрөнгө жил дунджаар 23.3%-аар өсчээ. Үүнээс, банкуудын хөрөнгө жилд дунджаар 23.0%, ББСБ-уудын хөрөнгө 33.4%, үнэт цаасны компаниудын хөрөнгө 25.6%, даатгалын компаниудын хөрөнгө 23.2%, ХЗХ-дын хөрөнгө 17.7%-ийн өсөлтийг тус тус үзүүлсэн байна.

Зураг 1. Санхүүгийн салбарын хөрөнгийн бүтэц, 2017 он



Эх сурвалж: Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо

Зураг 2. Санхүүгийн салбарын хөрөнгө 2010-2017 он, тэрбум төгрөг




Эх сурвалж: Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо

Санхүүгийн салбарын цэвэр ашиг

Монгол улсын санхүүгийн зах зээлд оролцогчдын нийт цэвэр ашиг 2017 оны байдлаар 335.2 тэрбум төгрөг байгаагаас банкуудын цэвэр ашиг 74.3%, ББСБ-уудын цэвэр ашиг 19.9%, үнэт цаасны компаниудын цэвэр ашиг 0.2%, даатгалын компаниудын цэвэр ашиг 3.9%, ХЗХ-дын цэвэр ашиг 1.6% тус тус бүрдүүлжээ.


2010-2017 оны санхүүгийн салбарын цэвэр ашиг жилд дунджаар 22.8%-аар өсчээ. Үүнээс, банкуудын цэвэр ашиг жилд дунджаар 21.0%, ББСБ-уудын цэвэр ашиг 37.6%, үнэт цаасны компаниудын цэвэр ашиг 4.1%, даатгалын компаниудын цэвэр ашиг 15.7%, ХЗХ-дын цэвэр ашиг 20.6%-ийн өсөлт үзүүлсэн байна.

Зураг 3. Санхүүгийн салбарын цэвэр ашгийн бүтэц, 2017 он



Эх сурвалж: Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо


Зураг 4. Санхүүгийн салбарын нийт цэвэр ашиг, алдагдал, 2010-2017 он, тэрбум төгрөг




Эх сурвалж: Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо

- ▶ Монгол улсын хөрөнгийн зах зээлийн хөгжил
 - Хөрөнгийн зах зээлд оролцогчид
 - Хөрөнгө оруулагчид
 - Хувьцаат компани
 - Бүртгэлтэй үнэт цаас
 - Үнэт цаасны арилжаа

1.2 ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТҮҮХЭН ДЭХ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ



- ▶ Монгол улсын хөрөнгийн зах зээлийн хөгжил
 - Хөрөнгийн зах зээлд оролцогчид
 - Хөрөнгө оруулагчид
 - Хувьцаат компани
 - Бүртгэлтэй үнэт цаас
 - Үнэт цаасны арилжаа



1.3 ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ


Зах зээлийн үнэлгээ

2017 оны байдлаар Монгол улсын үнэт цаасны зах зээлийн үнэлгээ 2,440.2 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх онтой харьцуулахад 966.0 тэрбум төгрөг буюу 65.5%-аар өссөн үзүүлэлттэй байна.

Тайлант онд зах зээлийн үнэлгээг 2017 оны жилийн эцсийн үйлдвэрлэлийн аргаар тооцсон нэрлэсэн дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээтэй харьцуулахад 9.0 хувийг эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 2.8 пунктээр өссөн үзүүлэлт юм.

Дэлхийн улс орнуудын хувьд дээрх харьцаа 2017 оны байдлаар дунджаар 98.2% байна.

Зураг 5. ДНБ-д эзлэх зах зээлийн үнэлгээ, 2017 он




Эх сурвалж: Дэлхийн банк, Санхүүгийн зохицуулах хороо

Хөрвөх чадвар

2017 онд үнэт цаасны зах зээлд нийт 860.7 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн нь өмнөх онтой харьцуулахад 512.1 тэрбум төгрөг буюу 146.9%-аар өссөн үзүүлэлттэй байна. Үүнээс, 78.1 тэрбум төгрөг нь хувьцааны арилжаа байсан бөгөөд үнэт цаасны зах зээлийн хөрвөх чадвар 3.2% болжээ. Энэ нь өмнөх онтой харьцуулахад 0.1 пунктээр буурсан үзүүлэлттэй юм.


Дэлхийн улс орнуудын хувьд дээрх харьцаа 2017 оны байдлаар дунджаар 100.4% байна.

Зураг 6. Хөрвөх чадвар, 2017 он



Эх сурвалж: Дэлхийн банк, Санхүүгийн зохицуулах хороо

Зураг 7. Хөрөнгийн зах зээлийн зарим үзүүлэлт



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо, МХБ, МҮЦБ

Үнэт цаасны зах зээлийн индекс

Зах зээлийн үр ашигтай байдлыг тухайн зах зээлийг төлөөлөх индексээр тодорхойлдог бөгөөд Монголын хөрөнгийн бирж 1999 онд хамгийн анхны ТОП-75 индексийг тооцож эхэлсэн байдаг. ТОП-75 индексийн сагс шилдэг 75 хувьцаат компанийн хувьцаанаас бүрддэг байв. 2003 оноос эхлэн Монголын хөрөнгийн бирж одоогийн ТОП-20 индексийг тооцох болсон ба улмаар 2015 оноос эхлэн MSE ALL индексийг давхар тооцох болжээ.

2017 онд ТОП-20 индексийн багц 1 болон 7 сард хоёр удаа шинэчлэгдсэн байна.

2017 оны эхний хагас жилийн үзүүлэлтээр ТОП-20 индексийн сагсыг шинэчлэхэд өмнөх сагсад багтаж байсан 16 компани хэвээр үлдэж, “УБ-БҮК”, “Гермес центр”, “Мерекс”, “Ремикон” ХК-иуд хасагдаж, шинээр “Бидисек”, “Гутал”, “Женко тур бюро”, “Монголын цахилгаан холбоо” ХК-иуд нэмэгдэн шинэчилсэн сагсыг бүрдүүлжээ.

Тайлант хугацаанд Монголын хөрөнгийн биржийн ТОП-20 индекс өмнөх онтой харьцуулахад 61.9%-аар өсч 20,106.78 нэгж болсон бөгөөд индексийн дээд үзүүлэлт 24,520.35 нэгж, доод үзүүлэлт 11,972.11 нэгж, дундаж үзүүлэлт 15,478.62 нэгж байна. 2010-2017 оны ТОП-20 индексийн үзүүлэлт жилд дунджаар 18.2 хувиар өссөн үзүүлэлттэй байжээ.

2017 онд MSE ALL индекс өмнөх оны мөн үетэй харьцуулахад 28.9%-аас өсч 1,106.7 нэгж болсон бөгөөд индексийн дээд үзүүлэлт 1,329.37 нэгж, доод үзүүлэлт 814.51 нэгж, дундаж үзүүлэлт 949.3 нэгж байна. 2015-2017 оны MSE ALL индексийн үзүүлэлт жилд дунджаар 5.3 хувиар өссөн үзүүлэлттэй байв.

Хүснэгт 1. ТОП-20 индексийн сагсыг бүрдүүлж буй ХК, 2017 он


№	Компани	Симбол	ЗЗҮ, тэрбум төгрөг
1	АПУ ХК	APU	762.7
2	Таван Толгой ХК	TTL	469.2
3	Говь ХК	GOV	181.5
4	Сүү ХК	SUU	87.7
5	Монгол шуудан ХК	MNP	55.0
6	Багануур ХК	BAN	48.2
7	Гутал ХК	GTL	30.7
8	Талх Чихэр ХК	TCK	30.6
9	Дархан нэхий ХК	NEH	24.2
10	Шарын гол ХК	SHG	23.4
11	Би Ди Сек ХК	BDS	20.6
12	Улсын их дэлгүүр ХК	UID	18.7
13	Материалимпекс ХК	MIE	14.9
14	Баянгол зочид буудал ХК	BNG	14.5
15	Монголын цахилгаан холбоо ХК	MCH	14.3
16	Ариг гал ХК	EER	13.7
17	Махимпекс ХК	MMX	10.9
18	Адуун чулуун ХК	ADL	9.8
19	Хөх ган ХК	HGN	7.1
20	Женко тур бюро ХК	JTB	6.1

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Зураг 8. Монголын хөрөнгийн биржийн ТОП-20 индекс



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

The background features a dark blue gradient with faint, semi-transparent financial charts, including a bar chart on the left and a candlestick chart on the right. A large, light blue diagonal shape cuts across the page from the bottom left towards the top right.

ХӨРӨНГИЙН
ЗАХ ЗЭЭЛД

ОРОЛЦОГЧИД

2

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛД ОРОЛЦОГЧИД 2017



САНГИЙН ЯАМ

ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖАА ЭРХЛЭХ
БАЙГУУЛЛАГА



2

ҮНЭТ ЦААСНЫ ТӨВЛӨРСӨН ХАДГАЛАМЖ,
ӨМЧЛӨХ ЭРХ БҮРТГЭЛИЙН БАЙГУУЛЛАГА

1



ҮНЭТ ЦААСНЫ ТӨЛБӨР ТООЦОО ГҮЙЦЭТГЭХ
БАЙГУУЛЛАГА

1



МОНГОЛБАНК МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

ҮНЭТ ЦААСНЫ ТӨЛБӨР ТООЦОО ГҮЙЦЭТГЭХ
(КЛИРИНГ) БАНК



КАСТОДИАН БАНК



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

ҮНЭТ ЦААСНЫ
КОМПАНИ

52

ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН САН

9

ХӨРӨНГӨ ИТГЭМЖЛЭН
УДИРДАХ ЭРХ БҮХИЙ
КОМПАНИ

3

ХӨРӨНГӨӨР
БАТАЛГААЖСАН
ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ

14

ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН
МЕНЕЖМЕНТИЙН
КОМПАНИ

17

МЭРГЭЖЛИЙН
ОРОЛЦОГЧДОД
ҮЙЛЧИЛГЭЭ
ҮЗҮҮЛЭГЧ КОМПАНИ

91

АУДИТЫН
КОМПАНИ

49

ҮНЭЛГЭЭНИЙ
КОМПАНИ

21

ХУУЛИЙН
КОМПАНИ

21



ӨӨРИЙГӨӨ ЗОХИЦУУЛАГЧ
БАЙГУУЛЛАГА

2

* Хувийн өмчит

- ▶ Хөрөнгийн зах зээлд оролцогчид
- Хөрөнгө оруулагчид
- Хувьцаат компани
- Бүртгэлтэй үнэт цаас
- Үнэт цаасны арилжаа

2.2 ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖАА ЭРХЛЭХ БАЙГУУЛЛАГА

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК

Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор улсын өмч хувьчлалын ажлыг эхлүүлэх, цаашид үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэх зорилгоор Монголын хөрөнгийн биржийг 1991 онд үүсгэн байгуулжээ.

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК нь үнэт цаас болон үүсмэл санхүүгийн хэрэгсэлтэй холбоотой гэрээ, хэлцэл байгуулах нөхцлийг бүрдүүлж, үнэт цаасны арилжааг зохион байгуулах байгууллага юм. Хөрөнгийн бирж нь хувьцаат компаниудын үнэт цаасыг тодорхой шалгуурын дагуу бүртгэн авч ангилал тогтоох, үнэт цаасны арилжааг ил тод, нээлттэй, шударга явуулж, олон нийтийг үнэт цаасны арилжааны мэдээ, мэдээллээр хангаж, хөрөнгө оруулагчдын нийтлэг эрх ашгийг хамгаалах үндсэн чиг үүрэгтэй.

“Монголын үнэт цаасны бирж” хаалттай ХК

Монголын үнэт цаасны бирж нь 2015 онд үнэт цаасны зах зээлд арилжааны болон тооцооны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлөө авч үйл ажиллагаагаа эхлүүлсэн. Тус байгууллага нь үнэт цаасны арилжааг зохион байгуулах, арилжааны дараах төлбөр тооцооны үйлчилгээ үзүүлдэг.

МҮЦБ нь маржин болон уламжлалт хосолсон арилжааг зохион байгуулах боломжтой.

Хүснэгт 2. Монголын хөрөнгийн бирж, 2017 он

Байгуулагдсан он	1991 он
Өмчийн хэлбэр	Төрийн өмчит хувьцаат компани
Бүртгэлтэй ХК-иудын нийт зах зээлийн үнэлгээ	2,436.3 сая төгрөг
2017 онд шинээр бүртгэгдсэн үнэт цаасны тоо	1 IPO, 1 бонд
Бүртгэлтэй ХК-ийн тоо	219
Гишүүн ҮЦК-ийн тоо	50
Арилжааны горим	T+1
Нийт хөрөнгө	4,970.7 сая төгрөг

Хүснэгт 3. Монголын үнэт цаасны бирж, 2017 он

Байгуулагдсан он	2015 он
Өмчийн хэлбэр	Хувийн өмчит хаалттай хувьцаат компани
Бүртгэлтэй ХК-иудын нийт зах зээлийн үнэлгээ	3.9 тэрбум төгрөг
2017 онд шинээр бүртгэгдсэн үнэт цаасны тоо	1 IPO
Бүртгэлтэй ХК-ийн тоо	1
Гишүүн ҮЦК-ийн тоо	9
Арилжааны горим	T+3
Нийт хөрөнгө	4,988.2 сая төгрөг

2.3 ҮНЭТ ЦААСНЫ ӨМЧЛӨХ ЭРХ БҮРТГЭЛИЙН БАЙГУУЛЛАГА

“Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК

“Үнэт цаасны төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК нь 2002 онд Монголын хөрөнгийн биржийн бүтцээс тусгаарлан 100% төрийн өмчит хуулийн этгээд болон үүсгэн байгуулагдаж, 2016 оноос эхлэн “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК болон өөрчлөн зохион байгуулагдсан.

Тус байгууллага нь үнэт цаасны өмчлөл, төвлөрсөн хадгаламжийн бүртгэлийг хөтлөх бөгөөд үнэт цаас гаргагчтай байгуулсан гэрээний үндсэн дээр үнэт цаасны өмчлөх эрх шилжүүлэхтэй холбоотой мэдээллийг хүлээн авч үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэлийн мэдээллийн санд оруулах, уг мэдээллийг хадгалах, боловсруулах, хууль тогтоомжийн дагуу тайлагнах, үнэт цаас гаргагчтай байгуулсан гэрээний үндсэн дээр үнэт цаасыг хадгалах, түүнтэй холбоотой бүртгэл хөтлөх үйл ажиллагааг явуулдаг.

Кастодиан банк

Үнэт цаас өмчлөгчийн үнэт цаасыг хадгалах, үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх бусад эрхийг хэрэгжүүлэхтэй холбоотой үйлчилгээг үзүүлэгч банк юм. Кастодиан банк нь өөрийн дансыг харилцагчийн данснаас тусад нь, харилцагч тус бүрийн дансыг тус тусад нь хөтөлж, найдвартай байдлыг хангаж ажилладаг.

2017 оны байдлаар Монгол улсад кастодиан банкны үйлчилгээ үзүүлэх эрхтэй 3 банк үйл ажиллагаагаа явуулж байна. Эдгээр нь “Худалдаа хөгжлийн банк”, “Хаан банк”, “Голомт банк” юм.

2.4 ҮНЭТ ЦААСНЫ ТӨЛБӨР ТООЦОО ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГА

“Арилжааны төлбөр тооцоо” ХХК

2015-2016 оны Сангийн сайдын тушаалын дагуу “Үнэт цаасны төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-ийг өөрчлөн зохион байгуулж, арилжааны төлбөр тооцоо гүйцэтгэх чиг үүрэг бүхий 100% төрийн өмчит “Арилжааны төлбөр тооцоо” ХХК үүсгэн байгуулагджээ.

“Арилжааны төлбөр тооцоо” ХХК нь үнэт цаасны арилжааны дараах төлбөр, тооцоог гүйцэтгэх байгууллага юм. Үнэт цаасны арилжааны дараа арилжаанд оролцогч талуудын гэрээ, хэлцлийн дагуу төлбөл зохих төлбөрийн гэрээ тус бүрээр болон нэгдсэн байдлаар тодорхойлж, холбогдох санхүүгийн бүртгэл, тооцооллыг хийн, төлбөрийн байгууллагад илгээх, даалгаврын дагуу үнэт цаас болон үнэт цаасны төлбөрийг шилжүүлэх, зохих мэдээллийг үнэт цаасны хадгаламжийн байгууллагад мэдэгдэнэ.

Тус компани нь Монголын хөрөнгийн бирж дээр арилжигдсан үнэт цаасны арилжааны төлбөр тооцоо, засгийн газрын үнэт цаасны үндсэн болон хүүгийн төлбөрийн гүйлгээг хийж гүйцэтгэж байна.

Клиринг банк

Төлбөр тооцоо гүйцэтгүүлэгчээс ирүүлсэн даалгаврын дагуу үнэт цаасны арилжааны мөнгөн төлбөр тооцоог гүйцэтгэх эрх бүхий хуулийн этгээд юм. Клирингийн үйлчилгээ гэдэг нь үнэт цаас худалдан авсан, худалдсан төлбөр тооцоог арилжааны банкинд байршуулсан дансаар дамжуулан хийх үйлчилгээ юм.

2017 оны байдлаар Монгол улсад 4 клирингийн банк үйл ажиллагаагаа явуулж байна. Эдгээр нь “Худалдаа хөгжлийн банк”, “Хаан банк”, “Голомт банк” болон “Хас банк” юм.

Монголын хөрөнгийн биржийн гишүүн 36 үнэт цаасны компаниас давхардсан тоогоор 22 нь “Хас банк”, 9 нь “Худалдаа хөгжлийн банк”, 7 нь “Голомт банк”, 6 нь “Хаан банк”-аар үнэт цаасны төлбөр тооцоогоо гүйцэтгэсэн байна.

“Арилжааны төлбөр тооцоо” ХХК нь 2017 онд цэвэршүүлсэн дүнгээр нийт 54.6 тэрбум төгрөгийн банк хоорондын гүйлгээг хийж гүйцэтгэсэнээс Хас банк 18.5 тэрбум төгрөг (33.9%), Хаан банк 13.3 тэрбум төгрөг (24.4%), Худалдаа хөгжлийн банк 11.4 тэрбум төгрөг (20.8%), Голомт банк 11.4 тэрбум төгрөгийн (20.8%) гүйлгээг тус тус гүйцэтгэжээ. Бусад хоёрдогч зах зээлийн арилжааны гүйлгээ клиринг банк дотроо явагдсан байна.

Хүснэгт 4. МХБ-ийн зарим гишүүн үнэт цаасны компаниудын клиринг банк сонгосон байдал, 2017 он

№	Үнэт цаасны компани	Клиринг банк
1	Апекс капитал	Голомт банк
2	Аргай бэст	Хас банк
3	Ард капитал групп	ХХБ
4	Ард секьюритиз	Хас банк
5	Батс	Хас банк
6	БиДиСек	Бүгд
7	Блюскай секьюритиз	Хас банк
8	Бумбат-Алтай	Хас банк
9	Гаули	Голомт банк
10	Гендекс	Хас банк
11	Голомт капитал	Голомт банк
12	Гранддевелопмент	Голомт банк
13	Гүүдсек	Хас банк
14	Дархан брокер	Хас банк
15	Дэлгэрхангай секьюритиз	Хас банк
16	Еврази капитал холдинг	ХХБ
17	Зэргэд	Хас банк
18	Зэт жи би	Хас банк
19	Лайфтайм инвестмент	Хас банк
20	Мирэ Эссэт Секьюритиз Монгол	Хаан банк, ХХБ
21	Монсек	Хаан банк
22	Мэргэн санаа	Хас банк
23	Новел инвестмент	Хаан банк, Хас банк
24	Нэйшнл сэкьюритиз	ХХБ
25	Өндөрхаан инвест	Хас банк
26	Санар	Хас банк
27	Сикап	Хас банк
28	Стандарт инвестмент	ХХБ
29	Ти Ди Би Капитал	ХХБ
30	Тулгат чандмань баян	Хас банк
31	Тэнгэр капитал	Хас банк
32	Хүннү Эмпайр	Хаан банк
33	Эм Ай Би Жи	ХХБ
34	Эс Жи Капитал	Хас банк
35	Эф Си Икс	Бүгд
36	Силвэр лайт секьюритиз	Голомт банк

Эх сурвалж: “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК судалгаа

- ▶ Хөрөнгийн зах зээлд оролцогчид
- Хөрөнгө оруулагчид
- Хувьцаат компани
- Бүртгэлтэй үнэт цаас
- Үнэт цаасны арилжаа


2.5 ҮНЭТ ЦААСНЫ КОМПАНИ

Үнэт цаасны компаниудын тусгай зөвшөөрөл

1991 онд “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК байгуулагдсанаас гадна өмч хувьчлалын эрхийн бичгийн бүртгэлийн болон брокерийн зуучлалын үйлчилгээг орон нутагт хүргэх зорилгоор 21 брокер, дилерийн пүүс анх байгуулагдаж байжээ. Брокерийн пүүсүүд нь тухайн орон нутгийн иргэдийн цэнхэр, ягаан тасалбарыг баталгаажуулан, хувьчлагдсан компанийн үнэт цаасанд анхдагч зах зээлийн арилжаагаар хөрвүүлэх бүртгэлийг хөтлөх, үнэт цаасны данс нээх ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байсан байна.


Монгол улсын хөрөнгийн зах зээлийн хөгжил болон “Эрдэнэс Таван Толгой” ХК-ийн хувьцааг Монгол Улсын иргэн бүрт эзэмшүүлэх болсонтой холбогдуулан 2012 онд үнэт цаасны компаниудын тоо 95 болж түүхэн дээд хэмжээнд хүрч байсан бол 2017 онд 52 компани болж буурчээ. СЗХ-оос олгосон тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлж буй үнэт цаасны компанийн тоо буурахад мэргэжлийн оролцогчдод тавигдах шалгуур үзүүлэлт чангарсан болон хөрөнгө оруулалтын орчин, үнэт цаасны компаниудын ашигт ажиллагаа зэрэг голлон нөлөөлжээ.

Зураг 10. Үнэт цаасны компаниудын тоо, тусгай зөвшөөрлийн төрлөөр



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Зураг 11. Үнэт цаасны компани болон тэдгээрийн салбарууд



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Хүснэгт 5. Үнэт цаасны компаниуд, тусгай зөвшөөрлийн төрлөөр

№	ҮЦК-ийн нэр	Брокер	Дилер	Андеррайтер	ХОЗ	№	ҮЦК-ийн нэр	Брокер	Дилер	Андеррайтер	ХОЗ
1	Азиа Пасифик Секьюритис	•	•			27	Капитал Маркет Корпораци	•	•	•	
2	Алтан Хоромсог	•	•			28	Лайфтайм Инвестмент	•	•	•	
3	Алекс Капитал	•	•			29	Масдак	•	•		
4	Аргай Бэст	•	•			30	Мирэ Эссет Секьюритис Монгол	•	•	•	•
5	Ард Капитал Групп	•	•	•		31	Монгол Секьюритиес	•	•		
6	Ард Секьюритиз	•	•	•	•	32	Монсек	•	•	•	
7	Асе Энд Т Капитал	•	•	•	•	33	Мэргэн Санаа	•	•		
8	Батс	•	•			34	Новел Инвестмент	•	•		•
9	Би Ди Сек	•	•	•	•	35	Нэйшнл Секьюритис	•	•	•	•
10	Блүмсбюри Секьюритис	•	•	•		36	Өндөрхаан Инвест	•	•		
11	Блэкстоун Интернэйшл	•	•			37	Санар	•	•		
12	Блюскай Секьюритиз	•	•			38	Сикап	•	•	•	•
13	Булган Брокер	•	•			39	Силвер Лайт Секоритиз	•			
14	Бумбат-Алтай	•	•	•		40	Стандарт Инвестмент	•	•	•	•
15	Гаули	•	•	•		41	Таван Богд	•	•		
16	Гацуурт Трейд	•	•			42	Ти Ди Би Капитал	•		•	
17	Гендекс	•	•			43	Тулгат Чандмань Баян	•	•		
18	Голомт Капитал	•		•	•	44	Тэнгэр Капитал	•	•	•	•
19	Гранд девелопмент	•	•			45	Фронтинер	•	•		
20	Гүүдсек	•	•	•	•	46	Хүннү Эмпайр	•	•		
21	Дархан Брокер	•	•			47	Эм Ай Би Жи	•	•	•	
22	Ди Си Эф	•	•			48	Эм Ай Си Си	•	•	•	
23	Дэлгэрхангай Секьюритиз	•	•			49	Эс Жи Капитал	•	•	•	•
24	Евразиа Капитал Холдинг	•	•	•	•	50	Эф Си Икс	•	•	•	
25	Зэргэд	•	•			51	Санлэвмэд*		•		•
26	Зэт Жи Би	•	•			52	Нэйшнл Инвестмент Менежмент*	•	•		

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж


*"Санлавмэд ҮЦК" ХХК болон "Нэйшнл Инвестмент Менежмент ҮЦК" ХХК нь МХБ болон МҮЦБ-д гишүүнчлэлгүй болно.

Үнэт цаасны компаниудын санхүүгийн үзүүлэлт

2010 онд 51 ҮЦК-ийн нийт хөрөнгийн хэмжээ 18.8 тэрбум төгрөг байсан бол 2017 онд 5 дахин өсч 92.8 тэрбум төгрөгт хүрчээ.

ҮЦК-иудын хөрөнгийн эх үүсвэрийн бүтцийн хувьд нийт хөрөнгийн 74.2% буюу 68.9 тэрбум төгрөг нь өөрийн хөрөнгө, 25.8% буюу 23.9 тэрбум төгрөг өр төлбөр байна.

Зураг 12. ҮЦК-иудын санхүүгийн үзүүлэлтүүд, тэрбум төгрөг



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Нийт хөрөнгө

Монголын хөрөнгийн биржид гишүүнчлэлтэй 50 ҮЦК-ийн нийт хөрөнгийн хэмжээ 2017 онд 92.8 тэрбум төгрөг байгаагаас хөрөнгийн хэмжээгээр тэргүүлж буй 5 үнэт цаасны компаниудын хөрөнгө нь нийт хөрөнгийн 75.3%-ийг бүрдүүлж байна.

Тайлант хугацаанд ҮЦК-уудын үндсэн үйл ажиллагааны орлого 13.7 тэрбум төгрөг, цэвэр ашиг 0.6 тэрбум төгрөг байв.

Хүснэгт 6. Хамгийн их хөрөнгөтэй ҮЦК-иудын санхүүгийн зарим үзүүлэлт, тэрбум төгрөг

№	Компанийн нэр	Нийт хөрөнгө	Үндсэн үйл ажиллагааны орлого	Цэвэр ашиг
1	Ти Ди Би Капитал	39.3	2.0	1.2
2	Би Ди Сек	18.9	6.3	1.2
3	Ард Капитал Групп	4.6	0.6	0.0
4	Мирэ Эссэт Секьюритис Монгол	3.6	0.4	0.1
5	Ард Секьюритиз	3.5	0.2	0.0
6	Бусад	22.9	4.2	(1.9)
	Нийт	92.8	13.7	0.6

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Хувь нийлүүлсэн хөрөнгө

СЗХ-ны 2016 оны “Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай зарим үйл ажиллагаа эрхлэх этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг тогтоох тухай” 94 дүгээр тогтоолоор зохицуулалттай этгээдүүдийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг шат дараатайгаар нэмэгдүүлэхээр шийдвэрлэж, 2017 оны 1 сарын 1-ний өдрөөс эхлэн хэрэгжиж эхэлжээ.

Хүснэгт 7. Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгийн шаардлага, сая төгрөг

Тусгай зөвшөөрөл	2016	2017
Хөрөнгө оруулалтын зөвлөх	10	30
Үнэт цаасны брокер	50	100
Үнэт цаасны дилер	50	200
Андеррайтер	200	1,000
Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага	1,000	2,000
Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага	100	2,000
Үнэт цаасны төлбөрийн байгууллага	100	2,000
Үнэт цаасны тооцооны байгууллага	100	2,000
Кастодиан банк	1,000	1,000

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Үнэт цаасны компаниудын арилжааны идэвх

Хувьцаа

МХБ дээр 2017 онд нийт 152.8 тэрбум төгрөгийн (авсан, зарсан нийлбэр дүнгээр) хувьцааны арилжаа явагдсанаас анхдагч зах зээлийн арилжаа 2.7 тэрбум төгрөг буюу нийт хувьцааны арилжааны 1.8%, хоёрдогч зах зээлийн арилжаа 150.2 тэрбум төгрөг буюу нийт хувьцааны арилжааны 98.2%-ийг тус тус бүрдүүлж байна.

Тайлант хугацаанд анхдагч зах зээлийн арилжаа МХБ дээр нэг удаа явагдаж, “Ай түүлс” ХК бүртгэгдсэн бөгөөд тус үнэт цаас гаргагчийн андеррайтераар ажилласан Стандарт Инвестмент ҮЦК нь анхдагч зах зээлийн арилжааны 73.9 хувийг гүйцэтгэжээ. Хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжаанд Ти Ди Би Капитал ҮЦК хамгийн идэвхтэй оролцож, арилжааны 50.2%-ийг гүйцэтгэсэн бол Би Ди Сек ҮЦК 16.9%, Голомт Капитал ҮЦК 11.3%, Стандарт Инвестмент ҮЦК 5.0%, харин үлдсэн 16.7%-ийг бусад ҮЦК-иуд тус тус гүйцэтгэжээ.

Засгийн газрын үнэт цаас

2017 онд МХБ дээр нийт 914.8 тэрбум төгрөгийн (авсан, зарсан нийлбэр үнийн дүнгээр) ЗГҮЦ-ны арилжаа явагдсанаас Засгийн газар 630.1 тэрбум төгрөгийн үнэт цаасыг анхдагч зах зээлд нийлүүлсэн ба ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээл дээр 284.7 тэрбум төгрөгийн арилжаа явагджээ.


ЗГҮЦ-ны анхдагч зах зээлийн арилжаанд Би Ди Сек ҮЦК хамгийн идэвхитэй оролцож арилжааны 35.9%-ийг гүйцэтгэсэн бол Мирэ Эссэт Секьюритис ҮЦК 20.0%, Новел Инвестмент ҮЦК 14.7%, бусад ҮЦК-иуд 29.3%-ийг тус тус гүйцэтгэжээ. ЗГҮЦ-ын хоёрдогч зах зээлийн арилжаанд Новел Инвестмент болон Мирэ Эссэт Секьюритис Монгол ҮЦК-иуд идэвхтэй оролцсон бөгөөд эдгээр хоёр компани нь нийт арилжааны 97.6%-ийг бүрдүүлсэн байна.

Компанийн бонд

Тайлант хугацаанд МХБ дээр “Сүү” ХК-ийн бонд шинээр бүртгэгдэж, тус бондын 12.0 тэрбум төгрөгийн (авсан, зарсан нийлбэр дүнгээр) анхдагч зах зээлийн арилжаа болон 8.3 тэрбум төгрөгийн (авсан, зарсан нийлбэр дүнгээр) хоёрдогч зах зээлийн арилжаа явагджээ.


Анхдагч зах зээлийн арилжааны 70.1 хувийг тус үнэт цаас гаргагчийн андеррайтераар ажилласан Голомт Капитал ҮЦК гүйцэтгэсэн бол хоёрдогч зах зээлийн арилжааны 47.4 хувийг Голомт Капитал ҮЦК, 28.6 хувийг Новел Инвестмент ҮЦК, 10.9 хувийг Ард Капитал ҮЦК, 13.1 хувийг бусад ҮЦК-иуд тус тус гүйцэтгэсэн байна.

Зураг 13. 2017 оны хувьцааны нийт арилжаа, авсан, зарсан нийлбэр үнийн дүнгээр



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Зураг 14. 2017 оны ЗГҮЦ-ны нийт арилжаа, авсан, зарсан нийлбэр үнийн дүнгээр



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Зураг 15. 2017 оны компанийн бондын нийт арилжаа, авсан, зарсан нийлбэр үнийн дүнгээр



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

The background of the page features a dark blue gradient with a faint, semi-transparent financial candlestick chart. The chart consists of vertical bars of varying heights, some with horizontal lines indicating price ranges, set against a grid. The overall aesthetic is professional and data-oriented.

ХӨРӨНГӨ

ОРУУЛАГЧИД

3


3.1 ҮНЭТ ЦААСНЫ ДАНС

Нийт данс

2017 оны жилийн эцсийн байдлаар ҮЦТХТ-д нийт 906,043 үнэт цаасны данс бүртгэлтэй байгаагаас дотоодын иргэд 901,129 данс буюу 99.5%, дотоодын ААН 2,633 данс буюу 0.3%, гадаадын иргэд 2,094 данс буюу 0.2%, гадаадын ААН 187 данс буюу 0.0%-ийг тус тус бүрдүүлжээ.

2010-2017 онд ҮЦТХТ-д бүртгэлтэй нийт дансны тоо жилд дунджаар 10.5%-аар өссөн үзүүлэлттэй байна.

Зураг 16. Нийт үнэт цаасны дансны тоо, мянган данс



Эх сурвалж: Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв


Шинэ данс

2012 онд “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааг иргэн бүрт эзэмшүүлэх шийдвэр гарсантай холбогдуулан ҮЦТХТ-д шинээр нээгдсэн үнэт цаасны данс 2012 онд түүхэн дээд хэмжээнд хүрч байжээ.

2017 онд ҮЦТХТ ХХК-д шинээр 19,544 данс нээгдсэнээс дотоодын иргэд 19,334 данс буюу 98.9%, дотоодын ААН 94 данс буюу 0.5%, гадаадын иргэд 107 данс буюу 0.5%, гадаадын ААН 9 данс буюу 0.0%-ийг тус тус нээжээ.


2010-2017 онд шинээр нээгдсэн дансны тоо жилд дунджаар 17.9%-аар өссөн үзүүлэлттэй байна.

Зураг 17. Шинээр нээгдсэн дансны тоо, мянган данс



Эх сурвалж: Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв

Зураг 18. Шинээр нээгдсэн дансны тоо, хөрөнгө оруулагчдын төрлөөр, 2010-2017 он



Эх сурвалж: Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв

3.2 АРИЛЖААНЫ ИДЭВХ


Хөрөнгө оруулагчдын арилжаанд эзлэх хувь

2012 онд эдийн засаг, уул уурхайн салбарын хөгжилтэй уялдан үнэт цаасны арилжаанд гадаадын хөрөнгө оруулагчид ихээр оролцох болж, нийт арилжааны 91.3%-ийг бүрдүүлсэн байна.

Харин 2013 оноос хойш үнэт цаасны арилжааны 88-аас дээш хувийг дотоодын хөрөнгө оруулагчид эзлэх болжээ. Үүнээс, дийлэнх хувийг дотоодын ААН-үүд бүрдүүлсэн байна.

2010-2017 онд дотоодын хөрөнгө оруулагчдын арилжааны үнийн дүн жилд дунджаар 50.6%-аар өссөн бол гадаад хөрөнгө оруулагчдын арилжааны үнийн дүн жилд дунджаар 3.9%-аар буурсан үзүүлэлттэй байна.

Зураг 19. Хөрөнгө оруулагчдын арилжаанд эзлэх хувь, 2010-2017 он




Эх сурвалж: Арилжааны төлбөр тооцоо

2017 оны арилжаа, хөрөнгө оруулагчдын төрлөөр

2017 онд МХБ дээр нийт 859.1 тэрбум төгрөгийн үнэт цаасны арилжаа хийгдсэнээс дотоодын иргэд 167.5 тэрбум төгрөг буюу 19.5%, дотоодын ААН 656.7 тэрбум төгрөг буюу 76.4%, гадаадын иргэд 24.3 тэрбум төгрөг буюу 2.8%, гадаадын ААН 10.6 тэрбум төгрөг буюу 1.2%-ийг тус тус бүрдүүлсэн байна.


2010-2017 онд нийт үнэт цаасны арилжаа жилд дунджаар 37.4%-аар өсчээ. Үүнээс, дотоодын иргэдийн арилжаа жилд дунджаар 56.7%, дотоодын ААН-ийн арилжаа 49.4%, гадаадын иргэдийн арилжаа 18.3% тус тус өссөн бол гадаадын ААН-ийн арилжаа жилд дунджаар 16.8%-аар буурсан үзүүлэлттэй байна.

Зураг 20. Хөрөнгө оруулагчдын арилжаанд эзлэх хувь, 2017 он



Эх сурвалж: Арилжааны төлбөр тооцоо

Зураг 21. Хөрөнгө оруулагчдын арилжааны идэвх, 2010-2017 он, тэрбум төгрөг



Эх сурвалж: Арилжааны төлбөр тооцоо


3.3 ХУВЬЦААНЫ ТӨВЛӨРӨЛ

Хувьцаа эзэмшигчдийн бүтэц

2017 оны байдлаар МХБ болон МҮЦБ-д бүртгэлтэй 219* компанийн нийт 5.7 тэрбум ширхэг хувьцааг 261.8 мянган хувьцаа эзэмшигч эзэмшиж байна.

Нийт хувьцаа эзэмшигчдийн 0.3 хувь болох том (5%-аас дээш хувь эзэмшиж буй) хувьцаа эзэмшигчид биржид бүртгэлтэй нийт хувьцааны 94.4 хувийг эзэмшиж байгаа бол үлдсэн 99.7 хувь болох жижиг хувьцаа эзэмшигчид биржид бүртгэлтэй нийт хувьцааны 5.6 хувийг эзэмшиж байна.

Зураг 22. Хувьцаат компанийн хувьцааны эзэмшигчдийн бүтэц, 2017 он



Эх сурвалж: "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК судалгаа


Хувьцааны төвлөрөл

2017 оны байдлаар МХБ болон МҮЦБ-д бүртгэлтэй 219* хувьцаат компанийн 68 нь 90-100 хүртэлх хувийн төвлөрөлтэй байна. Өөрөөр хэлбэл 68 хувьцаат компанийн нийт гаргасан хувьцааны 90-100% хувийг том хувьцаа эзэмшигчид эзэмшиж байгаа аж. Нийт биржид бүртгэлтэй хувьцаат компанийн төвлөрөл дунджаар 83 хувийн үзүүлэлттэй байна.

2017 онд 100 хувийн төвлөрөлтэй 23 хувьцаат компани байгаагаас 19 нь төрийн өмчит компани байв.

Жижиг хувьцаа эзэмшигчдийн дийлэнх буюу 129.2 мянган хувьцаа эзэмшигчид 60-70 хувийн төвлөрөлтэй компанийн хувьцааг эзэмшдэг аж.

Зураг 23. Хувьцаат компанийн төвлөрөл, 2017 он



Эх сурвалж: "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК судалгаа

Хүснэгт 8. Биржид бүртгэлтэй 219* хувьцаат компанийн хувьцааны төвлөрөл, 2017 он

Төвлөрөл /интервал/	Компанийн тоо	Нийт хувьцаа эзэмшигчдийн тоо	Том хувьцаа эзэмшигчдийн тоо	Жижиг хувьцаа эзэмшигчдийн тоо
10%	3	670	0	670
10-20%	0	0	0	0
20-30%	1	589	2	587
30-40%	2	5,218	6	5,212
40-50%	0	0	0	0
50-60%	5	2,640	20	2,620
60-70%	23	129,288	64	129,224
70-80%	31	30,981	104	30,877
80-90%	63	61,161	220	60,941
90-100%	68	31,239	259	30,980
100%	23	26	26	0
Нийт	219*	261,812	701	261,111

Эх сурвалж: "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК судалгаа

* МХБ-д бүртгэлтэй "Бэрэн майнинг" ХК-ийн гаргасан хувьцааны тоо 0 ширхэг учир тооцоололд багтаагүй болно.

The background features a dark blue gradient with faint, semi-transparent images of financial bar charts and network diagrams. A large, solid blue diagonal shape cuts across the page from the top right towards the bottom left.

ХУВЬЦААТ

КОМПАНИ

4

4.1 БҮРТГЭЛТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТОО

2017 оны жилийн эцсийн байдлаар СЗХ-нд 300, МХБ-д 219, МҮЦБ-д 1, ҮЦТХТ-д 313 хувьцаат компаниуд тус тус бүртгэлтэй байна. Арилжаа эрхлэх байгууллага болон СЗХ-нд бүртгэлтэй хувьцаат компанийн тоо зөрүүтэй байгаа явдал нь тус байгууллагуудын бүртгэлийн шаардлага болон бүртгэлээс хасах нөхцөл өөр байдагтай холбоотой юм. 2010-2017 онд биржид бүртгэлтэй хувьцаат компанийн тоо 336-аас 220 болж буурчээ.

Хувьцаат компанийн тоо, өмчийн хэлбэрээр

2017 оны жилийн эцсийн байдлаар МХБ болон МҮЦБ-д нийт 220 хувьцаат компани бүртгэлтэй байгаагаас 19 компани буюу 8.6% нь төрийн өмчит, 12 компани буюу 5.5% нь төрийн өмчийн орлоотой, 189 компани буюу 85.9% нь хувийн өмчийн компани байна.

2010-2017 онд төрийн өмчийн хувьцаат компанийн тоо 3-аар, төрийн өмчийн орлоотой хувьцаат компанийн тоо 17-оор, хувийн өмчит хувьцаат компанийн тоо 96-аар буурсан үзүүлэлттэй байна.

Хувьцаат компанийн тоо, салбараар

Үйл ажиллагааны салбараар нь авч үзвэл 2017 онд биржид бүртгэлтэй байгаа хувьцаат компаниудын 36 компани буюу 16.4% нь газар тариалан, мал аж ахуй, 29 компани буюу 13.2% нь барилга угсралт, 26 компани буюу 11.8% нь хүнсний үйлдвэрлэл, 22 компани буюу 10.0% нь уул, уурхай, 17 компани буюу 7.7% нь ложистик зэрэг салбарт үйл ажиллагаагаа явуулдаг ажээ.

Хувьцаат компанийн тоо, биржийн ангиллаар


2017 оны байдлаар биржид бүртгэлтэй 220 хувьцаат компанийн 9 буюу 4.1% нь МХБ-ийн I ангилалд, 41 компани буюу 18.6% нь МХБ-ийн II ангилалд, 169 компани буюу 76.8% нь МХБ-ийн III ангилалд, 1 компани буюу 0.5% нь МҮЦБ-д тус тус бүртгэлтэй байна.

Зураг 24. Биржид бүртгэлтэй ХК-ийн тоо, өмчийн хэлбэрээр, 2010-2017 он



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж, Монголын үнэт цаасны бирж

Зураг 25. Биржийн бүртгэлээс хасагдсан болон шинээр бүртгэгдсэн ХК-ийн тоо, 2010-2017 он




Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж, Монголын үнэт цаасны бирж

Зураг 26. Биржид бүртгэлтэй ХК-ийн тоо, салбараар, 2017 он



Эх сурвалж: "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК судалгаа

Зураг 27. Хувьцаат компанийн тоо, биржийн ангиллаар, 2017 он



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж, Монголын үнэт цаасны бирж

4.2 ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

Зах зээлийн үнэлгээ, биржийн ангиллаар

2017 оны жилийн эцсийн байдлаар МХБ болон МҮЦБ-д бүртгэлтэй 220 хувьцаат компанийн зах зээлийн үнэлгээ 2,440.2 тэрбум төгрөг байгаагаас МХБ-ийн I ангилалд бүртгэлтэй 9 компанийн ЗЗҮ 1,838.3 тэрбум төгрөг буюу 75.3%, МХБ-ийн II ангилалд бүртгэлтэй 41 компанийн ЗЗҮ 462.0 тэрбум төгрөг буюу 18.9%, МХБ-ийн III ангилалд бүртгэлтэй 169 компанийн ЗЗҮ 136.0 тэрбум төгрөг буюу 5.6%, МҮЦБ-д бүртгэлтэй 1 компанийн ЗЗҮ 3.9 тэрбум төгрөг буюу 0.2%-ийг тус тус бүрдүүлжээ.

2010-2017 онд МХБ болон МҮЦБ-ийн ЗЗҮ жилд дунджаар 8.6%-аар өсчээ. Үүнээс, МХБ-ийн I ангиллын компаниудын ЗЗҮ 19.8%-аар, МХБ-ийн III ангилалд бүртгэлтэй компаниудын ЗЗҮ 9.4%-аар өссөн бол МХБ-ийн II ангилалд бүртгэлтэй компаниудын зах зээлийн үнэлгээ 7.0%-аар буурсан үзүүлэлттэй байна.

Зах зээлийн үнэлгээ, салбараар


Үйл ажиллагаа явуулж буй салбараар нь авч үзвэл 2017 онд хүнсний үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаа явуулдаг компаниудын ЗЗҮ 919.1 тэрбум төгрөг буюу нийт ЗЗҮ-нд 37.7%, уул, уурхайн салбарт үйл ажиллагаа явуулдаг компаниудын ЗЗҮ 627.8 тэрбум төгрөг буюу 25.7%, санхүүгийн үйлчилгээ эрхэлдэг компаниудын ЗЗҮ 282.3 тэрбум төгрөг буюу 11.6%, нэхмэлийн үйлдвэрлэл эрхэлдэг компаниудын ЗЗҮ 194.3 тэрбум төгрөг буюу 8.0%, үл хөдлөх хөрөнгө, зочид буудал, түрээсийн үйл ажиллагаа явуулдаг компаниудын ЗЗҮ 110.1 тэрбум төгрөг буюу 4.5%, бусад салбарын компаниудын ЗЗҮ 306.6 тэрбум төгрөг буюу 12.6%-ийг тус тус бүрдүүлжээ.

Хамгийн өндөр зах зээлийн үнэлгээтэй ХК

2017 оны байдлаар хамгийн өндөр зах зээлийн үнэлгээтэй 5 хувьцаат компанийн ЗЗҮ нь нийт зах зээлийн үнэлгээний 70.4%-ийг бүрдүүлжээ.

2017 онд “АПУ” ХК-ийн ЗЗҮ 762.7 тэрбум төгрөгт хүрч нийт ЗЗҮ-нд 31.3%-ийг, “Таван толгой” ХК-ийн ЗЗҮ 469.2 тэрбум төгрөгт хүрч 19.2%-ийг, “МИК Холдинг” ХК-ийн ЗЗҮ 216.4 тэрбум төгрөгт хүрч 8.9%-ийг, “Говь” ХК-ийн ЗЗҮ 181.5 тэрбум төгрөгт хүрч 7.4%-ийг, “Сүү” ХК-ийн ЗЗҮ 87.7 тэрбум төгрөгт хүрч 3.6%-ийг тус тус бүрдүүлсэн үзүүлэлттэй байна.

Зураг 28. Хувьцаат компанийн зах зээлийн үнэлгээ, биржийн ангиллаар, тэрбум төгрөг




Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж, Монголын үнэт цаасны бирж

Зураг 29. Хувьцаат компанийн зах зээлийн үнэлгээ, салбараар, 2017 он



Эх сурвалж: “Ти Ди Би Kapital YЦК” ХХК судалгаа

Зураг 30. Хамгийн өндөр зах зээлийн үнэлгээтэй ХК, 2017 он



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж, Монголын үнэт цаасны бирж

4.3 АРИЛЖААНЫ ИДЭВХ

Хамгийн их хэмжээгээр арилжигдсан хувьцаа

2017 онд хамгийн ихээр арилжигдсан 5 хувьцааны арилжааны үнийн дүн нийт энгийн арилжааны 68.4%-ийг бүрдүүлсэн байна. Үүнээс, “АПУ” ХК-ийн хувьцаа хамгийн ихээр буюу нийт 8.5 тэрбум төгрөгөөр арилжигдаж, нийт арилжааны 27.7%-ийг бүрдүүлжээ. “Таван толгой” ХК-ийн хувьцаа 4.4 тэрбум төгрөгөөр арилжигдаж нийт арилжааны 14.4%-ийг, “Атар-Өргөө” ХК-ийн хувьцаа 4.0 тэрбум төгрөгөөр арилжигдаж нийт арилжааны 13.0%-ийг, “Говь” ХК-ийн хувьцаа 2.6 тэрбум төгрөгөөр арилжигдаж нийт арилжааны 8.5%-ийг, “Шивээ овоо” ХК-ийн хувьцаа 1.5 тэрбум төгрөгөөр арилжигдаж нийт арилжааны 4.8%-ийг тус тус бүрдүүлсэн үзүүлэлттэй байна.

Өсөлттэй хувьцаа

2017 онд МХБ-ийн 249 удаагийн арилжаагаар 132 компанийн хувьцаа, МҮЦБ-ээр дамжуулан 1 компанийн хувьцаа тус тус арилжигдсан байна. Эдгээр 133 компаниас 2016-2017 онд хувьцаа нь арилжигдсан, нэгж хувьцааны ханшийн өсөлтийг тооцох боломжтой 114 хувьцаат компанийн хувьцааны дундаж өсөлт 20.4%, эзэмших хугацааны өгөөжийн дундаж түвшин 21.6% байв.


Үүнээс, “Жинст-Увс” ХК-ийн хувьцаа хамгийн ихээр буюу 270.9%-аар өсч 1,858.00 төгрөгт, “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн хувьцаа 249.0%-аар өсч 3,507.00 төгрөгт, “Таван толгой” ХК-ийн хувьцаа 228.7%-аар өсч 8,910.00 төгрөгт, “Глобал Монголиа Ходинг” ХК-ийн хувьцаа 177.3%-аар өсч 1,109.00 төгрөгт, “Монноос” ХК-ийн хувьцаа 153.3%-аар өсч 3,799.00 төгрөгт тус тус хүрсэн үзүүлэлттэй байна.

“Таван толгой” ХК-ийн хувьцааны эзэмших хугацааны өгөөж хамгийн өндөр буюу 317.6% байв. Энэ нь тус компанийн хувьцааны ханш ихээр өссөн, компани их хэмжээний ногдол ашиг хуваарилсантай холбоотой ажээ.

Бууралттай хувьцаа


“Хай Би Ойл” ХК-ийн хувьцаа хамгийн ихээр буюу 72.2%-аар буурч 55.03 төгрөгт, “Төмрийн завод” ХК-ийн хувьцаа 57.1%-аар буурч 7,800.00 төгрөгт, “Еврофё азиа” ХК-ийн хувьцаа 47.6%-аар буурч 943.75 төгрөгт, “Стандарт ноос” ХК-ийн хувьцаа 45.6%-аар буурч 400.00 төгрөгт, “Улаансан” ХК-ийн хувьцаа 45.0%-аар буурч 1,100.00 төгрөгт тус тус хүрсэн үзүүлэлттэй байна.

Зураг 31. Хувьцаат компанийн хувьцааны энгийн арилжаа, тэрбум төгрөг




*Багцын арилжааны мэдээллийг 45-р хуудаснаас харна уу.
Эх сурвалж: “Ту Ди Би Капитал ҮЦК” ХХК судалгаа

Зураг 32. Нэгж хувьцааны ханшийн өсөлт болон эзэмших хугацааны өгөөж хамгийн өндөр хувьцаа, 2017 он



Эх сурвалж: “Ту Ди Би Капитал ҮЦК” ХХК судалгаа

Зураг 33. Хамгийн их бууралттай хувьцаа, 2017 он



Эх сурвалж: “Ту Ди Би Капитал ҮЦК” ХХК судалгаа

Хөрвөх чадвар

2017 онд арилжааны 249 өдөр байснаас 125-аас дээш өдөр арилжигдсан 15 компанийн хувьцаа биржийн нийт арилжааны 33.2%-ийг бүрдүүлжээ. Эдгээр компаниудын 8 нь Монголын хөрөнгийг биржийн I ангилалд, 7 нь II ангилалд бүртгэлтэй байна.

“Говь” болон “Таван толгой” ХК-иудын хувьцаа хамгийн олон өдөр буюу 242 өдөр арилжигдсан бол “АПУ” ХК-ийн хувьцаа 236 өдөр, “Сүү” ХК-ийн хувьцаа 232 өдөр, “Ремикон” ХК-ийн хувьцаа 208 өдөр тус тус арилжигдсан үзүүлэлттэй байна.

Эдгээр 15 хувьцаат компаниас “Женко тур бюро” ХК-ийн хувьцааны эргэц 55.6%, “Монгол шуудан” ХК-ийн хувьцааны эргэц 47.7%, “Ремикон” ХК-ийн хувьцааны эргэц 29.3%, “Монголын цахилгаан холбоо” ХК-ийн хувьцааны эргэц 23.4%, “Сүү” ХК-ийн хувьцааны эргэц 21.2%, “АПУ” ХК-ийн хувьцааны эргэц 20.5%-тай тус тус тэнцжээ.

Хувьцааны хөрвөх чадварын хувьд “Женко тур бюро” ХК-ийн хувьцааны хөрвөх чадвар 15.5%, “Ремикон” ХК-ийнх 9.9%, “Махимпекс” ХК-ийнх 6.8%, “Монгол шуудан” ХК-ийнх 2.1%, “Адуун чулуун” ХК-ийнх 1.9%-ийн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 9. Хувьцаат компанийн хувьцаа арилжигдсан өдрүүд, 2017 он

№	Арилжигдсан өдөр /интервал/	Компанийн тоо
1	Хувьцаа нь арилжигдаагүй	87
2	1-20 өдөр арилжигдсан	70
3	21-40 өдөр арилжигдсан	26
4	41-60 өдөр арилжигдсан	5
5	61-80 өдөр арилжигдсан	6
6	81-100 өдөр арилжигдсан	4
7	101-120 өдөр арилжигдсан	6
8	121-140 өдөр арилжигдсан	4
9	141-160 өдөр арилжигдсан	2
10	161-180 өдөр арилжигдсан	2
11	181-200 өдөр арилжигдсан	2
12	201-220 өдөр арилжигдсан	2
13	220-оос дээш өдөр арилжигдсан	4
Нийт		220

Эх сурвалж: “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК судалгаа

Хүснэгт 10. 2017 онд 125-аас дээш өдөр арилжигдсан хувьцаа

№	Компанийн нэр	Симбол	Ангилал	Арилжигдсан өдөр	Хувьцааны эргэц*	Хувьцааны хөрвөх чадвар**	Нийт арилжаа, сая төгрөг
1	Говь ХК	GOV	I	242	11.3%	1.4%	2,598.9
2	Таван толгой ХК	TTL	I	242	13.4%	1.0%	4,707.5
3	АПУ ХК	APU	I	236	20.5%	1.6%	12,268.7
4	Сүү ХК	SUU	I	232	21.2%	0.9%	832.6
5	Ремикон ХК	RMC	II	208	29.3%	9.9%	286.9
6	Монгол шуудан ХК	MNP	I	205	47.7%	2.1%	1,150.5
7	Женко тур бюро ХК	JTB	II	192	55.6%	15.5%	938.7
8	Улсын их дэлгүүр ХК	UID	II	190	2.1%	0.8%	149.8
9	Махимпекс ХК	MMX	I	179	10.1%	6.8%	743.0
10	Талх чихэр ХК	TCK	I	165	6.6%	1.4%	439.9
11	Багануур ХК	BAN	II	156	7.4%	0.3%	129.5
12	Адуун чулуун ХК	ADL	II	148	18.8%	1.9%	182.6
13	Монголын цахилгаан холбоо ХК	MCH	II	130	23.4%	1.2%	176.0
14	Дархан нэхий ХК	NEH	I	130	2.8%	0.7%	179.8
15	Ариг гал ХК	EER	II	128	9.5%	1.2%	171.3

Эх сурвалж: “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК судалгаа

* Хувьцааны эргэц - Компанийн энгийн арилжаагаар арилжаалагдсан хувьцааны тоо ширхэгийг олон нийтэд чөлөөтэй хөрвөх хувьцааны тоо ширхэгт харьцуулсан харьцаа.

** Хувьцааны хөрвөх чадвар - Компанийн хувьцааны нийт арилжааг тус компанийн зах зээлийн үнэлгээтэй харьцуулсан харьцаа.


4.5 САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Нийт хөрөнгө

2017 онд биржид санхүүгийн тайлангаа ирүүлсэн 182 ХК-ийн нийт хөрөнгө 8,206.9 тэрбум төгрөг байгаагаас эргэлтийн хөрөнгө 4,800.9 тэрбум төгрөг буюу 58.5%, эргэлтийн бус хөрөнгө 3,406.0 тэрбум төгрөг буюу 41.5% байна. 2010-2017 онд хувьцаат компанийн нийт хөрөнгө жилд дунджаар 49.5%, эргэлтийн хөрөнгө 27.9%, эргэлтийн бус хөрөнгө 37.6% тус тус өссөн үзүүлэлттэй байна.


2017 онд нийт хөрөнгийн эх үүсвэрийн 56.9% буюу 4,668.4 тэрбум төгрөг нь өр төлбөр, 43.1% буюу 3,538.5 тэрбум төгрөг нь өөрийн хөрөнгө байна. 2010-2017 онд биржид бүртгэлтэй хувьцаат компанийн нийт өр төлбөр жилд дунджаар 44.0%, өөрийн хөрөнгө 32.6% тус тус өсчээ.

Зураг 34. Хувьцаат компаниудын нийт хөрөнгийн бүтэц, 2017 он



Эх сурвалж: "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК судалгаа

Зураг 35. Хувьцаат компаниудын хөрөнгө, 2010-2017 он, тэрбум төгрөг




Эх сурвалж: "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК судалгаа

Хамгийн их хөрөнгөтэй хувьцаат компани

2017 оны байдлаар хамгийн их хөрөнгөтэй 5 хувьцаат компанийн хөрөнгө биржид бүртгэлтэй компанийн нийт хөрөнгийн 58.1%-ийг бүрдүүлжээ.

2017 онд "МИК Холдинг" ХК-ийн хөрөнгө 2,778.9 тэрбум төгрөгт хүрч нийт хувьцаат компанийн хөрөнгөд 33.9%-ийг, "АПУ" ХК-ийн хөрөнгө 632.9 тэрбум төгрөгт хүрч нийт хөрөнгөд 7.7%-ийг, "Монголын төмөр зам" ТӨХК-ийн хөрөнгө 575.1 тэрбум төгрөгт хүрч нийт хөрөнгийн 7.0%-ийг, "ДЦС-4" ТӨХК-ийн хөрөнгө 438.1 тэрбум төгрөгт хүрч нийт хөрөнгийн 5.3%-ийг, "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ТӨХК-ийн хөрөнгө 341.3 тэрбум төгрөгт хүрч нийт хөрөнгийн 4.1%-ийг тус тус бүрдүүлсэн үзүүлэлттэй байна.

Зураг 36. 2017 онд хамгийн их хөрөнгөтэй хувьцаат компаниуд, тэрбум төгрөг



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж, Монголын үнэт цаасны бирж


Ашигт ажиллагаа

2017 онд санхүүгийн тайлангаа ирүүлсэн 182 ХК-ийн нийт борлуулалтын орлого 2,843.1 тэрбум төгрөг, үйл ажиллагааны ашиг буюу нийт ашиг 831.8 тэрбум төгрөг, тайлант үеийн цэвэр ашиг 246.4 тэрбум төгрөгтэй тэнцжээ.

Эдгээрээс 88 компани 284.5 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай, 73 компани 38.1 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан бол 21 хувьцаат компани үйл ажиллагаа явуулаагүй байна.

2010-2017 онд хувьцаат компаниудын борлуулалтын орлого жилд дунджаар 23.9%, үйл ажиллагааны ашиг жилд дунджаар 23.2%, цэвэр ашиг жилд дунджаар 10.6%-аар өссөн үзүүлэлттэй байна.

Зураг 37. Хувьцаат компаниудын ашигт ажиллагаа, 2010-2017 он, тэрбум төгрөг




Эх сурвалж: "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК судалгаа

Хамгийн өндөр ашигтай ажилласан хувьцаат компани

2017 онд "Тавантолгой" ХК-ийн цэвэр ашиг 141.1 тэрбум төгрөгт хүрч, нийт ашигтай ажилласан 88 ХК-ийн цэвэр ашгийн 49.6%-ийг бүрдүүлжээ.

Мөн тайлант хугацаанд "МИК Холдинг" ХК-ийн цэвэр ашиг 65.0 тэрбум төгрөг буюу 22.9%, "АПУ" ХК-ийн цэвэр ашиг 24.9 тэрбум төгрөг буюу 8.7%, "Говь" ХК-ийн цэвэр ашиг 17.5 тэрбум төгрөг буюу 6.1%, "Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" ХК-ийн цэвэр ашиг 2.9 тэрбум төгрөгт хүрч нийт ашгийн 1.0%-ийг тус тус бүрдүүлсэн үзүүлэлттэй байна.

Зураг 38. 2017 онд хамгийн их ашигтай ажилласан хувьцаат компани, тэрбум төгрөг




Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж, Монголын үнэт цаасны бирж

Хамгийн их алдагдалтай ажилласан компани

2017 онд "Цемент шохой" ХК 7.5 тэрбум төгрөгийн алдагдалтай ажиллаж, нийт алдагдалтай ажилласан 73 ХК-ийн цэвэр алдагдлын 19.8%-ийг, "Хай Би Ойл" ХК-ийн цэвэр алдагдал 3.7 тэрбум төгрөг буюу 9.7%, "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК-ийн цэвэр алдагдал 3.5 тэрбум төгрөг буюу 9.2%, "Дарханы дулааны сүлжээ" ХК-ийн цэвэр алдагдал 3.1 тэрбум төгрөг буюу 8.0%, "Дарханы дулааны цахилгаан станц" ХК-ийн цэвэр алдагдал 2.4 тэрбум төгрөгт хүрч нийт цэвэр алдагдлын 6.4%-ийг тус тус бүрдүүлсэн үзүүлэлттэй байна.

Зураг 39. 2017 онд хамгийн их алдагдалтай ажилласан хувьцаат компани, тэрбум төгрөг



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж, Монголын үнэт цаасны бирж


4.6 КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

Хувьцаат компанийн үндсэн үүргийн хэрэгжилт

МХБ нь хувьцаат компанийн үндсэн үүргийн хэрэгжилтийг хувьцаа эзэмшигчдийн хурлаа хуралдуулсан байдал, санхүүгийн тайлангаа хуульд заасан хугацаанд ирүүлсэн байдал, ногдол ашиг хуваарилсан эсэх гэсэн 3 үндсэн үзүүлэлтээр дүгнэж байна.

2017 оны байдлаар МХБ болон МҮЦБ-д бүртгэлтэй нийт 220 ХК-ийн 64.5% буюу 142 компани хувьцаа эзэмшигчдийн хурлаа хуралдуулсан, 55.9% буюу 123 нь санхүүгийн тайлангаа хуульд заасан хугацаанд ирүүлсэн, 11.8% буюу 26 компани ногдол ашиг хуваарилсан байна.

Зураг 40. Хувьцаат компанийн үндсэн үүргийн хэрэгжилт, 2017 он



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж, Монголын үнэт цаасны бирж

Зураг 41. МХБ болон МҮЦБ-д бүртгэлтэй ХК-ийн тоо, 2010-2017 он



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж, Монголын үнэт цаасны бирж

Зураг 42. Ногдол ашиг хуваарилсан ХК-ийн тоо, 2010-2017 он



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж

Зураг 43. Хувьцаа эзэмшигчдийн хурлаа хуралдуулсан ХК-ийн тоо, 2010-2017 он



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Зураг 44. Санхүүгийн тайлангаа хуульд заасан хугацаанд ирүүлсэн ХК-ийн тоо, 2010-2017 он



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо


4.7 НОГДОЛ АШИГ

2017 онд МХБ болон МҮЦБ-д бүртгэлтэй 220 хувьцаат компаниас 26 нь нийт 323.4 тэрбум төгрөгийн ашигтай ажиллаж, хувьцаа эзэмшигчдэд нийт 143.7 тэрбум төгрөгийн ногдол ашиг хуваарилжээ.

2010-2017 онд хувьцаат компаниудын нийт хуваарилсан ногдол ашгийн хэмжээ жилд дунджаар 9.9%-аар өссөн үзүүлэлттэй байна.

2017 онд ногдол ашиг төлөлтийн харьцааны дундаж үзүүлэлт 39.8 хувьтай байгаа аж.

Зураг 45. Ногдол ашиг хуваарилалт, тэрбум төгрөг



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж, Монголын үнэт цаасны бирж

Хүснэгт 11. Ногдол ашиг хуваарилсан хувьцаат компаниуд, 2017 он

№	Компанийн нэр	Симбол	Ангилал	Нийт цэвэр ашиг, сая төгрөг	Ногдол ашиг төлөлтийн харьцаа	Нийт ногдол ашиг, сая төгрөг	Нэгж хувьцааны ногдол ашиг, төгрөг
1	Таван Толгой ХК	TTL	I	141,054.6	90.0%	126,923.1	2,410.0
2	АПУ ХК	APU	I	24,871.9	42.8%	10,641.8	10.0
3	Говь ХК	GOV	I	17,474.7	9.8%	1,716.2	220.0
4	Сүү ХК	SUU	I	2,430.1	42.5%	1,032.0	3.0
5	Жуулчин дюти фрий ХК	SUL	II	1,070.7	61.0%	653.6	10,000.0
6	Адуун чулуун ХК	ADL	II	435.5	94.1%	409.7	130.0
7	Гермес центр ХК	HRM	II	715.4	54.9%	392.7	5.0
8	Махимпекс ХК	MMX	I	354.8	107.1%	380.1	100.0
9	Монгол шуудан ХК	MNP	I	911.8	40.2%	366.5	3.68
10	Талх чихэр ХК	TCK	I	1,128.0	15.4%	174.0	170.0
11	Баянгол зочид буудал ХК	BNG	II	2,481.2	6.1%	150.2	355.0
12	Тахь-ко ХК	TAH	II	790.1	16.3%	128.5	108.0
13	Анд-Энерги ХК	AND	МҮЦБ	121,400.0	0.1%	99.1	1.27
14	Гутал ХК	GTL	II	2,492.8	3.3%	83.0	1,270.0
15	Могойн гол ХК	BDL	II	245.6	33.8%	83.0	100.0
16	Тээвэр дархан ХК	TEE	III	38.7	211.2%	81.7	500.0
17	Ариг гал ХК	EER	II	148.5	50.0%	74.2	21.33
18	Хүрд ХК	HRD	III	694.4	9.7%	67.2	497.0
19	Улаанбаатар хивс ХК	UBH	II	247.1	16.4%	40.5	100.0
20	Монгол алт ХК	ERS	III	74.2	53.7%	39.9	150.0
21	Талын гал ХК	TAL	III	143.2	24.2%	34.7	50.0
22	Барилга корпораци ХК	BRC	III	397.2	7.2%	28.5	700.0
23	Баянтээг ХК	BTG	II	1,131.6	2.2%	25.3	100.0
24	Ган Хийц	GHC	II	(158.9)		24.2	100.0
25	Материалимпекс ХК	MIE	II	493.0	2.8%	13.7	10.0
26	Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ ХК	DSS	III	2,329.1	0.3%	7.7	56.6
Нийт				323,395.4		143,671.1	17,170.9

Эх сурвалж: Ти Ди Би Кпитал ҮЦК ХХК судалгаа



БҮРТГЭЛТЭЙ

ҮНЭТ ЦААС

5

5.1 БИРЖИЙН ЗАХ ЗЭЭЛД БҮРТГЭЛТЭЙ ҮНЭТ ЦААС

Нийт үнэт цаас

2017 оны байдлаар биржийн зах зээлд нийт 7.5 тэрбум ширхэг үнэт цаас бүртгэлтэй байгаагаас 99.9% буюу 7.48 тэрбум ширхэг нь хувьцаа, 0.1% буюу 3.9 сая ширхэг нь бонд байна.

2010-2017 онд нийт биржийн зах зээлд бүртгэлтэй үнэт цаасны тоо жилд дунджаар 14.4%-аар өсчээ. Үүнээс, биржийн зах зээлд бүртгэлтэй хувьцааны тоо жилд дунджаар 14.4%, бондын тоо жилд дунджаар 30.6%-аар өссөн үзүүлэлттэй байна.

Хувьцаа

2017 оны байдлаар биржийн зах зээлд нийт 313 нээлттэй хувьцаат компанийн 7,476,703 мянган ширхэг хувьцаа бүртгэлтэй байгаагаас төрийн мэдлийн хувьцаа 2,818,124 мянган ширхэг буюу 37.7%, орон нутгийн оролцоотой хувьцаа 29,046 мянган ширхэг буюу 0.4%, төрийн мэдлийн бус хувьцаа 4,629,533 мянган ширхэг буюу 61.9%-ийг тус тус бүрдүүлжээ.


2010-2017 онд биржийн зах зээлд бүртгэлтэй төрийн мэдлийн хувьцаа жилд дунджаар 5.9%, төрийн мэдлийн бус хувьцаа 23.9%-аар тус тус өссөн бол 2011 оноос хойш орон нутгийн оролцоотой хувьцааны тоонд өөрчлөлт ороогүй ажээ.

Бонд

2017 оны байдлаар биржийн зах зээлд нийт 3,860 мянган ширхэг бонд бүртгэлтэй байгаагаас Засгийн газрын бонд 3,567 ширхэг буюу 92.4%, компанийн бонд 293 мянган ширхэг буюу 7.6%-ийг тус тус бүрдүүлжээ.

2010-2017 онд биржийн зах зээлд бүртгэлтэй Засгийн газрын бондын тоо жилд дунджаар 175.0%-аар өссөн бол компанийн бондын тоо жилд дунджаар 9.6%-аар буурсан үзүүлэлттэй байна.

Зураг 46. Биржийн зах зээлд бүртгэлтэй үнэт цаасны тоо, тэрбум ширхэг



Эх сурвалж: Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв

Зураг 47. Биржийн зах зээлд бүртгэлтэй хувьцааны тоо, тэрбум ширхэг



Эх сурвалж: Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв

Зураг 48. Биржийн зах зээлд бүртгэлтэй бондын тоо, сая ширхэг



Эх сурвалж: Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв

5.2 БИРЖИЙН БУС ЗАХ ЗЭЭЛД БҮРТГЭЛТЭЙ ҮНЭТ ЦААС

Хувьцаа

2017 оны байдлаар биржийн бус зах зээлд нийт 6 хаалттай хувьцаат компанийн 5.2 тэрбум ширхэг хувьцаа, “Эрдэнэс таван толгой” ХК-ийн 15.0 тэрбум ширхэг хувьцаа болон 31.7 сая ширхэг бонд бүртгэлтэй байна.

2015-2017 онд нийт биржийн бус зах зээлд бүртгэлтэй үнэт цаасны тоо жилд дунджаар 417.7%-аар өссөн үзүүлэлттэй байна.

“Эрдэнэс таван толгой” ХК-ийн хувьцаа

Монгол улсын Засгийн газрын 2017 оны 5-р сарын 30-ны өдрийн 154-р тогтоолд заасны дагуу ҮЦТХТ ХХК-д бүртгэлтэй “Эрдэнэс таван толгой” ХК-ийн төрийн мэдлийн 9.8 тэрбум ширхэг хувьцааг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн эзэмшилд шилжүүлж, 3 тэрбум ширхэг хувьцааг арилжигдаагүй үлдэгдлээр бүртгэсэн байна.

Ингэснээр “Эрдэнэс таван толгой” ХК-ийн нийт 15 тэрбум ширхэг хувьцааны 65.2 хувийг төрийн өмчит “Эрдэнэс Монгол” ХХК, 14.7 хувийг 2012 оны 4-р сарын 11-ний өдрөөс өмнө төрсөн Монгол улсын иргэд, 0.05 хувийг дотоодын ААН тус тус эзэмшиж байна.

Иргэдийн эзэмшлийн 2.2 тэрбум ширхэг хувьцааг 2.8 сая иргэн эзэмшиж байгаа бөгөөд эдгээр иргэдээс 33 орчим хувь нь үнэт цаасны дансаа нээж, өмчлөх эрхээ баталгаажуулжээ.

Бонд

2017 оны байдлаар биржийн бус зах зээлд нийт 31,667 мянган ширхэг бонд бүртгэлтэй байгаагаас Засгийн газрын бонд 1,988 мянган ширхэг буюу 6.3%, компанийн бонд 29,679 мянган ширхэг буюу 93.7%-ийг тус тус бүрдүүлжээ.


2011-2017 онд биржийн бус зах зээлд бүртгэлтэй бондын тоо жилд дунджаар 77.2%-аар өссөн үзүүлэлттэй байна. Үүнээс, Засгийн газрын бондын тоо жилд дунджаар 12.1%-аар, компанийн бондын тоо жилд дунджаар 233.4%-аар өсчээ.

Хүснэгт 12. Биржийн бус зах зээлд бүртгэлтэй хувьцаа, 2017 он

№	Компанийн нэр	Бүртгэгдсэн огноо	Нийт хувьцаа, ширхэг
1	Эрдэнэс таван толгой	2011	15,000,000,000
2	Хөдөө аж ахуйн давхар даатгал	2015	150,000,000
3	Ард санхүүгийн нэгдэл	2015	22,752,700
4	Апи ресурс	2016	2,205,000
5	Монгол базальт	2017	39,491,900
6	Стор альянс фонд	2017	49,900
7	Монголын үнэт цаасны бирж	2017	5,000,000,000
Нийт			20,214,499,500

Эх сурвалж: Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв

Зураг 49. “Эрдэнэс таван толгой” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц, 2017 он



Эх сурвалж: Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв

Зураг 50. Биржийн бус зах зээлд бүртгэлтэй бондын тоо, мянган ширхэг



Эх сурвалж: Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв


5.3 ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААС

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас

2017 онд “МИК Холдинг” ХК-ийн охин компани болох “МИК ОССК” ХХК-ийн үүсгэн байгуулсан “МИК актив арван хоёр ТЗК”, “МИК актив арван гурав ТЗК”, “МИК актив арван дөрөв ТЗК” тусгай зориулалтын компанийн нийт 9,818 зээлдэгчдийн зээлийн багц бүхий 591.8 тэрбум төгрөгийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг бүртгэсэн байна.

Ингэснээр 2015-2017 онд ҮЦТХТ ХХК нь нийт 14 тусгай зориулалтын компанийн 3,288.5 тэрбум төгрөгийн үнэт цаас шинээр бүртгэгдсэнээс 2017 оны байдлаар 62,003 зээлдэгчдийн зээлийн багц бүхий 3,250.8 тэрбум төгрөгийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас бүртгэлтэй байна.

Зураг 51. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны үнийн дүн болон зээлдэгчдийн тоо, тэрбум төгрөг



Эх сурвалж: Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв

Хүснэгт 13. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас

№	Үнэт цаас гаргагч	Нийт гаргасан үнэт цаас, тэрбум төгрөг	2017 оны байдлаар ҮЦТХТ-д бүртгэлтэй үнэт цаас, тэрбум төгрөг	Зээлдэгчдийн тоо
2015 он				
1	МИК актив 1 ТЗК ХХК	328.1	322.9	6,658
2	МИК актив 2 ТЗК ХХК	224.8	222.1	5,290
3	МИК актив 3 ТЗК ХХК	328.5	324.6	6,593
4	МИК актив 4 ТЗК ХХК	429.4	452.3	9,510
5	МИК актив 5 ТЗК ХХК	301.2	294.3	5,802
6	МИК актив 6 ТЗК ХХК	267.8	261.7	5,188
7	МИК актив 7 ТЗК ХХК	299.6	293.8	5,414
Нийт		2,179.4	2,171.7	44,455
2016 он				
8	МИК актив 8 ТЗК ХХК	189.8	186.3	3,291
9	МИК актив 9 ТЗК ХХК	137.5	137.2	1,719
10	МИК актив 10 ТЗК ХХК	103.0	96.3	1,585
11	МИК актив 11 ТЗК ХХК	70.9	67.5	1,135
Нийт		501.2	487.3	7,730
2017 он				
12	МИК актив 12 ТЗК ХХК	272.3	262.4	4,439
13	МИК актив 13 ТЗК ХХК	190.3	190.2	3,039
14	МИК актив 14 ТЗК ХХК	145.3	139.2	2,340
Нийт		607.9	591.8	9,818
НИЙТ		3,288.5	3,250.8	62,003

Эх сурвалж: Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв

The background features a dark blue gradient with faint, semi-transparent financial charts, including a candlestick chart on the left and a bar chart on the right. A large, light blue geometric shape, resembling a stylized '6' or a large number, is positioned in the lower-left quadrant. The text is centered in the upper-right area.

ҮНЭТ ЦААСНЫ

АРИЛЖАА

6

ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖАА 2017 ОН



НИЙТ
АРИЛЖАА

ХУВЬЦАА



ЗАСГИЙН ГАЗРЫН
ҮНЭТ ЦААС



КОМПАНИЙН БОНД

Анхдагч
зах зээл

2.9

тэрбум төгрөг

630.1

тэрбум төгрөг

6.0

тэрбум төгрөг

39.9

сая ширхэг

6.7

сая ширхэг

60.0

сая ширхэг

Хоёрдогч
зах зээл

75.2

тэрбум төгрөг

142.3

тэрбум төгрөг

4.2

тэрбум төгрөг

92.6

сая ширхэг

1.4

сая ширхэг

41.6

мянган ширхэг

860.7
тэрбум төгрөг

78.1

тэрбум төгрөг

772.5

тэрбум төгрөг

10.2

тэрбум төгрөг



МОНГОЛЫН
ХӨРӨНГИЙН БИРЖ

76.4

тэрбум төгрөг



МОНГОЛЫН ҮНЭТ
ЦААСНЫ БИРЖ

1.7

тэрбум төгрөг

Засгийн Газрын
Үнэт Цаас

ЖИГНЭСЭН ДУНДАЖ
ХҮҮ

14.2%

(жилийн)

2017 оны 11-р сараас эхлэн
Засгийн Газрын Үнэт Цаасны
анхдагч зах зээлийн арилжаа
зогссон.

6.1 АРИЛЖААНЫ ЕРӨНХИЙ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Нийт арилжаа

2010-2017 онд Монголын хөрөнгийн зах зээл дээрх нийт үнэт цаасны арилжааны жилийн дундаж өсөлт 37.4% байсан бөгөөд 2017 онд арилжааны хэмжээ өмнөх оны үзүүлэлтээс 2.5 дахин өссөн байна. Энэхүү өсөлтийн голлох шалтгаан нь ЗГҮЦ-ны арилжаа 2014 оны 11-р сараас 2017 оны 11-р сар хүртэл МХБ-ээр дамжин олон нийтэд арилжаалагдаж байсантай холбоотой юм.

2017 онд нийт үнэт цаасны арилжаа 860.7 тэрбум төгрөгт хүрсэн ба үүнээс 772.5 тэрбум төгрөг буюу 89.7 хувийг ЗГҮЦ-ны арилжаа, 78.1 тэрбум төгрөг буюу 9.1 хувийг хувьцааны арилжаа, 10.2 тэрбум төгрөг буюу 1.2 хувийг компанийн бондын арилжаа тус тус эзэлж байна.


Анхдагч зах зээлийн арилжаа

2017 оны байдлаар үнэт цаасны анхдагч зах зээл дээр 39.9 сая ширхэг хувьцааг 2.9 тэрбум төгрөгөөр, 6.7 сая ширхэг Засгийн Газрын Үнэт Цаасыг 630.1 тэрбум төгрөгөөр, 60.0 мянган ширхэг компанийн бондыг 6.0 тэрбум төгрөгөөр тус тус арилжиж, нийт 639.1 тэрбум төгрөгийн арилжаа явагдсан байна.

Хоёрдогч зах зээлийн арилжаа


2017 оны байдлаар үнэт цаасны хоёрдогч зах зээлд 249 удаагийн арилжаагаар 133 компанийн 92.6 сая ширхэг хувьцааг 75.2 тэрбум төгрөгөөр арилжсан ба 1.4 сая ширхэг Засгийн Газрын Үнэт Цаасыг 142.3 тэрбум төгрөгөөр, 41.6 мянган ширхэг компанийн бондыг 4.2 тэрбум төгрөгөөр тус тус арилжиж, нийт 221.6 тэрбум төгрөгийн арилжаа явагдсан байна.

Зураг 52. Үнэт цаасны арилжаа, тэрбум төгрөг




Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж, Монголын үнэт цаасны бирж

Зураг 53. 2017 оны анхдагч зах зээлийн арилжаа, тэрбум төгрөг



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж, Монголын үнэт цаасны бирж

Зураг 54. 2017 оны хоёрдогч зах зээлийн арилжаа, тэрбум төгрөг



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж, Монголын үнэт цаасны бирж


6.2 ХУВЬЦААНЫ АРИЛЖАА

Нийт арилжаа

2010-2017 онуудад хөрөнгийн зах зээл дээрх нийт хувьцааны арилжааны жилийн дундаж өсөлт 3.1% байсан бөгөөд 2017 онд нийт хувьцааны арилжаа 78.1 тэрбум төгрөг байсан нь өмнөх оны үзүүлэлтээс 59.4%-аар өсчээ.

Бүтцийн хувьд 2017 онд анхдагч зах зээлийн арилжаа 2.9 тэрбум төгрөг буюу нийт хувьцааны арилжааны 3.7%, хоёрдогч зах зээлийн арилжаа 75.2 тэрбум төгрөг буюу нийт хувьцааны арилжааны 96.3%-ийг тус тус бүрдүүлжээ. Хоёрдогч зах зээлийн арилжааны 44.6 тэрбум төгрөг буюу нийт хувьцааны арилжааны 57.1% нь багцын арилжаа байв.

Зураг 55. Хувьцааны арилжаа, тэрбум төгрөг



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж, Монголын үнэт цаасны бирж

Анхдагч зах зээлийн арилжаа

2010-2017 онд хувьцааны анхдагч зах зээл дээр нийт 12 хувьцаат компанийн 76.4 тэрбум төгрөгийн арилжаа явагдсан. Үүнээс, 5 хувьцаат компани үнэт цаасаа олон нийтэд анх удаа санал болгон 42.1 тэрбум төгрөгийн хөрөнгийг, 7 хувьцаат компани нэмэлт хувьцаа гарган 34.3 тэрбум төгрөгийн хөрөнгийг татан төвлөрүүлжээ.

2017 онд 2 хувьцаат компани 2.9 тэрбум төгрөгийн IPO хийснээс МХБ-д бүртгэгдсэн "Ай Түүлс" ХК 1.3 тэрбум, МҮЦБ-д бүртгэгдсэн "Анд Энерги" ХК 1.6 тэрбум төгрөг олон нийтээс татан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 14. Хувьцааны анхдагч зах зээлийн арилжааны түүх, 2010-2017 он

Компани	Симбол	Биржийн ангилал	Салбар	Бүртгэсэн огноо	Татан төвлөрүүлсэн хөрөнгө, сая төгрөг
IPO					
Э-Транс ложистикс ХК	ETR	II	Ложистик	2012.04.09	924.0
Мерекс ХК	MRX	II	Барилгын материалын үйлдвэрлэл	2014.01.14	965.9
МИК холдинг ХК	MIK	I	Санхүүгийн үйлчилгээ	2015.12.21	37,276.8
Ай түүлс ХК	ITLS	II	Мэдээлэл технологи	2017.09.27	1,338.8
Анд Энерги ХК	AND	МҮЦБ	Цахилгааны угсралт, суурилуулалт, автоматжуулалт	2017.10.10	1,592.6
Нийт					42,098.1
FPO					
Хай би ойл ХК	HBO	II	Газрын тос олборлолт	2010.08.25	99.2
Нако түлш ХК	NKT	II	Кокс болон газрын тосны боловсруулсан бүтээгдэхүүний үйлдвэрлэл	2010.08.25	270.3
Шарын гол ХК	SHG	II	Чулуун, хүрэн нүүрс олборлолт	2011.01.13	5,456.0
Силикат ХК	SIL	III	Бусад ашигт малтмал олборлолт	2011.05.06	3,650.0
Шарын гол ХК	SHG	II	Чулуун, хүрэн нүүрс олборлолт	2011.10.13	18,301.4
Бинсэ ХК	BHR	III	Мал эмнэлгийн үйл ажиллагаа	2015.05.04	300.0
Монгол шуудан ХК	MNP	I	Ложистик	2015.12.22	6,264.0
Нийт					34,341.0
НИЙТ					76,439.1

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж, Монголын үнэт цаасны бирж

2017 оны IPO үр дүн

2017 онд 2 хувьцаат компани IPO хийснээс МҮЦБ-д бүртгэгдсэн “Анд Энерги” ХК-ийн анхдагч зах зээлийн хувьцааны захиалга 1.8 тэрбум төгрөгт хүрч, нийлүүлэлтээ 1.11 дахин давсан бол МХБ-д бүртгэгдсэн “Ай Түүлс” ХК-ийн анхдагч зах зээлийн захиалга 4.0 тэрбум төгрөгт хүрч, нийлүүлэлтээ 2.97 дахин давсан үзүүлэлттэй байна.

“Анд Энерги” ХК-ийн олон нийтэд санал болгосон 1.6 тэрбум төгрөгийн хувьцааг нийт 436 хөрөнгө оруулагч худалдан авснаас, 428 дотоодын иргэн 98.3%-ийг, 7 дотоодын ААН 1.6%-ийг, 1 гадаадын иргэн 0.04%-ийг тус тус худалдан авчээ.

Харин “Ай түүлс” ХК-ийн олон нийтэд санал болгосон 1.3 тэрбум төгрөгийн хувьцааг нийт 955 хөрөнгө оруулагч худалдан авснаас, 936 дотоодын иргэн 88.1%-ийг, 5 дотоодын ААН 1.5%-ийг, 14 гадаадын иргэн 10.5%-ийг тус тус худалдан авсан байна.

Хүснэгт 15. Анхдагч зах зээлийн арилжаанд оролцсон хөрөнгө оруулагчид, 2017 он

Төрөл	Тоо	Үнийн дүн	Эзлэх хувь
“Анд Энерги” ХК			
Гадаадын ААН	0	0	0.0%
Гадаадын иргэн	1	600,000	0.0%
Дотоодын ААН	7	26,043,480	1.6%
Дотоодын иргэн	428	1,565,760,000	98.3%
Нийт	436	1,592,403,480	100%
“Ай түүлс” ХК			
Гадаадын ААН	0	0	0.0%
Гадаадын иргэн	14	139,935,000	10.5%
Дотоодын ААН	5	19,891,500	1.5%
Дотоодын иргэн	936	1,178,971,500	88.1%
Нийт	955	1,338,798,000	100%

Эх сурвалж: Монголын үнэт цаасны бирж, Арилжааны төлбөр тооцоо

Хүснэгт 16. IPO, 2017 он

	“Анд Энерги” ХК	“Ай түүлс” ХК
Компанийн товч танилцуулга		
Байгуулагдсан он	2011 он	2011 он
Үйл ажиллагааны чиглэл	LED гэрэл, гэрэлтүүлгийн үйлдвэрлэл, худалдаа	Мэдээллийн технологи /Дата төв, клоуд майнинг/
Бүртгэгдсэн бирж	МҮЦБ	МХБ
Хувьцааны үнэлгээ		
Нэгж хувьцааны нэрлэсэн үнэ	1 төгрөг	43 төгрөг
IPO гаргахаас өмнөх дансны үнэ	6.6 төгрөг	67.4 төгрөг
Нэгж хувьцааны тооцсон зах зээлийн үнэ цэнэ	60 төгрөг	128 төгрөг
Олон нийтэд санал болгосон нэгж хувьцааны үнэ	60 төгрөг	100 төгрөг
IPO мэдээлэл		
Олон нийтэд санал болгосон хувь	34.00%	38.86%
Энгийн хувьцааны тоо		
IPO гаргахаас өмнөх хувьцааны тоо	51,526,700 ширхэг	21,064,144 ширхэг
Олон нийтэд санал болгосон хувьцааны тоо	26,544,058 ширхэг	13,387,980 ширхэг
IPO гаргасны дараах хувьцааны тоо	78,070,758 ширхэг	34,452,124 ширхэг
Анхдагч зах зээлийн захиалга		
Захиалга авсан хугацаа	2017.10.25-2017.10.31	2017.11.01-2017.11.10
Татан төвлөрүүлэх хөрөнгө	1,592,643,480 төгрөг	1,338,798,000 төгрөг
Нийт захиалгын сан	1,774,557,039 төгрөг /1.11 дахин их/	3,978,699,600 төгрөг /2.97 дахин их/
Захиалга өгсөн хүн, ААН-ийн тоо	436	955
Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт	Үйл ажиллагаагаа өргөжүүлэх, эргэлтийн хөрөнгийн санхүүжилт	Дархан хот дахь модулятор дата төвийн парк
Андеррайтер	“Бумбат-Алтай ҮЦК” ХХК	“Стандарт инвестмент ҮЦК” ХХК
Ногдол ашгийн бодлого	Цэвэр ашгийн 5-8%	Тодорхой хувь заагаагүй


Эх сурвалж: “Анд Энерги” ХК болон “Ай түүлс” ХК-ийн үнэт цаасны танилцуулга, Арилжааны төлбөр тооцоо

Хоёрдогч зах зээлийн энгийн арилжаа

2017 онд МХБ болон МҮЦБ-д бүртгэлтэй хувьцаат компанийн хоёрдогч зах зээлийн энгийн арилжаа 30.5 тэрбум төгрөг байгаагаас МХБ-ийн I ангиллын компаниудын хувьцааны арилжаа 18.5 тэрбум төгрөг буюу 60.5%, МХБ-ийн II ангиллын компаниудын хувьцааны арилжаа 11.4 тэрбум төгрөг буюу 37.2%, МХБ-ийн III ангиллын компаниудын хувьцааны арилжаа 601.2 сая төгрөг буюу 2.0%, МҮЦБ-д бүртгэлтэй компанийн хувьцааны арилжаа 86.5 сая төгрөг буюу 0.3%-ийг тус тус бүрдүүлжээ.


Салбараар нь авч үзвэл хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаагаа явуулдаг компаниудын хувьцаа 46.6%, аялал жуулчлалын салбарын компаниудын хувьцаа 3.2%, барилгын материал үйлдвэрлэгч компаниудын хувьцаа 2.2%, мэдээлэл, технологийн салбарын компаниудын хувьцаа 4.7% тус тус бүрдүүлжээ.

Зураг 56. Хувьцааны хоёрдогч зах зээлийн энгийн арилжаа, биржийн ангиллаар, 2017 он



Эх сурвалж: “Ту Ди Би Капитал ҮЦК” ХХК судалгаа

Зураг 57. Хувьцааны хоёрдогч зах зээлийн энгийн арилжаа, үйл ажиллагааны салбараар, 2017 он



Эх сурвалж: “Ту Ди Би Капитал ҮЦК” ХХК судалгаа

Хоёрдогч зах зээлийн багцын арилжаа

2017 онд багцын арилжаагаар “АПУ”, “Би Ди Сек”, “Дархан зочид буудал”, “Дархан Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ”, “Махимпекс”, “МИК Холдинг”, “Монгол савхи”, “Таван толгой”, “Шарын гол” зэрэг нийт 9 компанийн 14.3 сая ширхэг хувьцааг 44.6 тэрбум төгрөгөөр арилжжээ.

Үүнээс хамгийн их дүнтэй багцын арилжаа нь “МИК Холдинг” ХК-ийн 36.0 тэрбум төгрөгийн арилжаа байсан бөгөөд нийт хоёрдогч зах зээлийн арилжааны 47.9%-ийг бүрдүүлсэн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 17. МХБ дээр явагдсан багцын арилжаа, 2017 он

№	Компани	Симбол	Тоо ширхэг	Үнийн дүн, сая төгрөг
1	АПУ ХК	APU	5,553,000	3,810.1
2	Би ди сек ХК	BDS	1,054,301	105.4
3	Дархан зочид буудал ХК	DZG	12,973	1.3
4	Дархан Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ ХК	DSS	1,869,321	2,998.4
5	Махимпекс ХК	MMX	483,198	434.9
6	МИК Холдинг ХК	MIK	3,243,827	36,038.9
7	Монгол савхи ХК	UYN	868,392	486.3
8	Таван толгой ХК	TTL	1,023,100	306.9
9	Шарын гол ХК	SHG	219,330	410.1
Нийт			14,327,442	44,592.4

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

6.3 ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖАА


ЗГҮЦ-ны арилжаа

Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 10-р сарын 21-ний өдрийн 389 дугаар тогтоол болон Монголын хөрөнгийн биржийн Гүйцэтгэх захирлын 2014 оны 10-р сарын 23-ны өдрийн 169 дугаар тушаалаар 2014 оны 11-р сараас эхлэн Монгол Улсын Засгийн газрын үнэт цаасыг Монголын хөрөнгийн биржээр дамжуулан хөрөнгийн зах зээлд арилжаалах болсон.

Тус үнэт цаасыг Сангийн яамнаас ирүүлсэн нөхцөлийн дагуу олон нийтэд санал болгон нэг бүр нь 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэйгээр долоо хоног бүр арилжаалсан бөгөөд үнэт цаасны хүүгийн хэмжээ нь тухайн долоо хоногт Монголбанкинд арилжигдсан ижил хугацаатай ЗГҮЦ-ны жигнэсэн дундаж хүүгийн хэмжээгээр тогтоогддог байна.

Харин 2017 оны 11-р сараас эхлэн ЗГҮЦ-ны анхдагч зах зээлийн арилжаа түр хугацаагаар зогссон билээ.

Зураг 58. ЗГҮЦ-ны арилжаа, 2014-2017 он, тэрбум төгрөг



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

2017 оны арилжаа

2017 онд ЗГҮЦ-ны 772.5 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэнээс 630.1 тэрбум төгрөг буюу 81.6 хувийг анхдагч зах зээлийн арилжаа, 142.3 тэрбум төгрөг буюу 18.4 хувийг хоёрдогч зах зээлийн арилжаа эзэлж байна.

52 долоо хоног хүртэлх хугацаатай ЗГҮЦ-ны арилжаа нь нийт арилжааны 84.8%-ийг эзэлжээ.


ЗГҮЦ-ны жигнэсэн дундаж хүү 12 долоо хоногтой нь 13.8%, 28 долоо хоногтой нь 13.9%, 39 долоо хоногтой нь 14.5%, 52 долоо хоногтой нь 14.2%, 104 долоо хоногтой нь 15.7%, 156 долоо хоногтой нь 16.0% тус тус байсан байна.

Зураг 59. ЗГҮЦ-ны арилжаа, 2017 он, тэрбум төгрөг




Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Зураг 60. 2017 оны ЗГҮЦ-ны анхдагч зах зээлийн арилжаа, хугацааны ангиллаар








Эх сурвалж: "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК судалгаа

Зураг 61. 2017 оны ЗГҮЦ-ны захиалга болон нийлүүлэлт, сараар, тэрбум төгрөг



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Зураг 62. 2017 онд арилжаалагдсан ЗГҮЦ-ны хүү, үнэт цаасны хугацааны ангиллаар, сараар




Эх сурвалж: "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК судалгаа

6.4 КОМПАНИЙН БОНДЫН АРИЛЖАА

Монголын хөрөнгийн биржийн түүхэнд 2001-2015 оны хооронд нийт 14 компанийн бонд гарч байсан бол 2017 оны 6-р сард Монголын хөрөнгийн биржийн 1-р ангилалд бүртгэлтэй компани болох “Сүү” ХК 6 тэрбум төгрөгийн дүнтэй 17.5%-ийн хүүтэй, 12 сарын хугацаатай “Сүү бонд” гаргасан байна.

“Сүү бонд”-ын анхдагч зах зээлийн арилжаанд нийт 67,547 ширхэг буюу 6,754,700,000 төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авах захиалга бүртгэгдсэн нь үнэт цаас гаргагчийн санал болгосон хэмжээнээс 13%-аар давсан үзүүлэлттэй байжээ.

Зураг 63. 2017 оны компанийн бондын арилжаа



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Хүснэгт 18. Монголын хөрөнгийн бирж дээр гаргасан компанийн бондын түүх, 2001-2017 он

№	Үнэт цаасны нэр	Үнэт цаас гаргагч	Хугацаа /сар/	Хүү /жилийн/	Тоо ширхэг	Валют	Татан төвлөрүүлсэн хөрөнгө	Бүртгэгдсэн он
1	Шинэ зуун 210	Барилга Корпораци ХК	10	19.60%	537,700	MNT	5,335,680,000	2001
2	Их барилга	Алтан хот корпораци ХХК	8	19.80%	100,000	MNT	996,920,000	2002
3	Нийслэл өргөө	Нийслэл Өргөө ХК	12	19.70%	240,000	MNT	1,200,000,000	2002
4	Их барилга төсөл	Их Барилга Төсөл ХХК	8	19.80%	26,000	MNT	1,300,000,000	2003
5	Анод	Анод банк	24	19.60%	200,000	MNT	209,490,000	2004
6	MCS Электроникс	Эм Си Эс Электроникс ХХК	12	11.00%	14,728	USD	500,000	2004
7	MCS Электроникс	Эм Си Эс Электроникс ХХК	18	19.00%	22,000	MNT	872,640,000	2004
8	Пума	Пума групп ХХК	12	21.60%	100,000	MNT	1,000,000,000	2004
9	Бүтээн байгуулалт	Монинжбар ХК	18	21.60%	50,000	MNT	500,000,000	2005
10	Говь	Говь ХК	12	19.20%	100,000	MNT	1,000,000,000	2005
11	Монфрэш	Монфрэш жүүс ХХК	12	11.00%	100,000	USD	156,920	2007
12	Бүтээн байгуулалт	Монинжбар ХК	24	11.10%	120,000	MNT	502,000,000	2008
13	Мах бонд	Жаст Агро ХХК	12	16.20%	3,000,000	MNT	4,399,540,000	2011
14	Эрчим бонд	Эрчим Инженеринг ХХК	6	18.50%	50,000	MNT	500,000,000	2015
15	Сүү бонд	Сүү ХК	12	17.50%	60,000	MNT	6,000,000,000	2017

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж



70100261, 70100263



info@tdbcapital.mn



www.tdbcapital.mn